



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Эрчимтэй боловч тэнцвэргүй өсөлт

Тусгай сэдэв – Цахим үйлчилгээний салбар дахь
худалдааны боломжууд

2023 оны 11 сар



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Эрчимтэй боловч тэнцвэргүй өсөлт

2023 оны 11 сар

Энэхүү тайлан нь Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн бүтээл бөгөөд бусад гаднын байгууллагууд хувь нэмэр оруулж хамтарсан. Тайланд тусгасан үр дүн, тайлбар, дүгнэлт зэрэг нь Дэлхийн Банк, Дэлхийн Банкны Гүйцэтгэх Захирлууд болон тэдний төлөөлж буй улс орнуудын Засгийн газрын байр суурийг илэрхийлэх албагүй болно. Дэлхийн Банк энэ тайланд дурдагдсан мэдээ мэдээллийн үнэн бодит эсэхэд баталгаа өгөхгүй болно.

Эрх ба зөвшөөрөл

Энэ бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан. Уг бүтээлээс зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн, эсвэл бүхлээр нь хуулбарласан тохиолдолд холбогдох хуулийг зөрчиж буйд тооцогдоно. Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк / Дэлхийн Банк нь өөрийн ажлыг түгээн дэлгэрүүлэхийг хөхиүлэн дэмждэг бөгөөд хэсэгчлэн хэвлэн тараах зөвшөөрлийг шуурхай олгоно. Энэхүү бүтээлийн аль нэг хэсгийг хуулбарлах, эсвэл хувилах зөвшөөрөл авах хүсэлтээ бүрэн гүйцэд мэдээллийн хамт дараах хаягаар илгээнэ үү: Copyright Clearance Center, Inc., 22 Rosewood Drive, Danvers, MA 01923, USA, утас 978-750-8400, факс 978-750-4470, <http://www.copyright.com/>. Өөр бусад хэлбэрээр хэвлэн нийтлэх эрх, холбогдох зөвшөөрөл авах талаар асууж тодруулах бол дараах хаягаар хандана уу: Office of the Publisher, The World Bank, 1818 H Street, NW, Washington, DC 20433, USA, fax 202-522-2422, e-mail pubrights@worldbank.org.

Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ТАЛАРХАЛ.....	5
ХУРААНГУЙ	6
Бүлэг I: Эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв	16
1. Эдийн засгийн өнөөгийн байдал	16
1.1 Уул уурхайн салбар, төсвийн зардал тэлснээр эдийн засгийн өсөлт эрчимжив	16
1.2 Инфляц алгуур буурч байгаа ч өндөр түвшинд хадгалагдсаар байна	21
1.3 Арилжааны банкнууд зээлийн нөхцөлөө чанга хэвээр хадгалж, эрсдэлээс сэргийлэх бодлого баримталж байна	23
1.4 Төсвийн тэнцэл сайжирсан ч гадаад сөрөг нөлөөлөлд өртөмтгий хэвээр байна	24
1.5 Экспорт эрчимжиж урсгал данс ашигтай гарах, гадаад валютын улсын нөөцийг хуримтлуулахад эергээр нөлөөлж байна.....	28
2. Эдийн засгийн хэтийн төлөв, эрсдэл, бодлогын зөвлөмж	32
2.1. Эдийн засгийн хэтийн төлөв, эрсдэл	32
2.2. Бодлогын зөвлөмж	34
Бүлэг 2: Цахим үйлчилгээний салбар дахь худалдааны боломжууд	38
1. Цахим шилжилтийн үйл явц болон цахим үйлчилгээний экспортод тулгарч буй сорилтууд	38
2. Цахим үйлчилгээний экспортыг хөхиүлэн дэмжих нь	42
Ашигласан материалын жагсаалт	46

Шигтгээ, зураг, хүснэгтийн жагсаалт

Шигтгээ

Шигтгээ I.1.	Дэлхийн эдийн засгийн болон түүхий эдийн үнийн хандлага ^a	20
Шигтгээ I.2.	Монголын нүүрсний экспортын үнэ: БНХАУ руу экспортлогч бусад улс орнуудтай харьцуулах нь	31
Шигтгээ I.3.	Нүүрс ба уур амьсгалын өөрчлөлт	35

Зураг

Зураг Х.1.	Эдийн засгийн өсөлт жигд бус бөгөөд өсөлтийн дийлэнхийг уул уурхайн, тэр дундаа нүүрсний олборлох үйлдвэрлэл,	12
Зураг Х.2	... цэвэр экспорт болон төсвийн зардлын өсөлт тайлбарлаж байна.	12
Зураг Х.3.	Дотоодод үйлдвэрлэгдсэн бараа, үйлчилгээний үнэ тогтмол өсөж, улмаар инфляц өндөр түвшинд хадгалагдан, өрхийн бодит орлогод сөргөөр нөлөөлж байна.	13
Зураг Х.4.	Хувийн хэвшилд олгож буй зээлийн өсөлт хязгаарлагдмал байгаа нь хувийн хөрөнгө оруулалтыг сааруулах нөлөө үзүүлж байна.....	13
Зураг Х.5.	Төсвийн нийт зарлага эргэн өсөж,.....	13
Зураг Х.6.	... уул уурхайн салбараас төвлөрөх орлогын өсөлтөөр санхүүжигдэж байна.....	13
Зураг Х.7.	Экспортын хэмжээ огцом нэмэгдсэнээр урсгал дансны тэнцэл ашигтай гарч	14
Зураг Х.8	... хөрөнгийн орох урсгал бага байснаас үл хамааран гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэв.....	14
Зураг Х.9.	МХХТ-ийн салбарт олон төрөлт үйлчилгээ үзүүлэх болон программ хангамж хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд ашиг орлогоороо тэргүүлж байна.....	14
Зураг Х.10.	Монгол Улсын кибер аюулгүй байдлын үзүүлэлт сул байна.	14
Зураг I.1.	Уул уурхайн үйлдвэрлэл мэдэгдэхүйц тэлснээр эдийн засгийн өсөлт хурдсаж байна	16
Зураг I.2.	Уул уурхайн салбарын үйлдвэрлэлд нүүрсний олборлолт давамгайлж байна	17
Зураг I.3.	Бусад салбарын өсөлт удаашралтай байна	17
Зураг I.4.	Гадаад эрэлт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн	18
Зураг I.5.	... уул уурхайн бүтээгдэхүүний үнэ харьцангуй нам түвшинд байсан ч экспортын биет хэмжээ өслөө.....	18
Зураг I.6.	Хөдөлмөрийн зах зээлээс гарч буй хүн амын тоо нэмэгдэж байгаа нь зах зээлийн идэвхжилийг сулруулж байна.....	19
Зураг I.7	Өндөр инфляц өрхийн бодит орлогыг сааруулах нөлөө үзүүлж байна.	19
Зураг Ш.1.	Дэлхийн эдийн засгийн сэргэлт цар тахлын дараах эрчээ алдаж байна.....	20
Зураг Ш.2.	Түүхий эд, таваарын үнэ буурах хандлагатай байна	21
Зураг I.8.	2023 онд импортын барааны инфляц буурсан ч дотоодод үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үнийн өсөлт өндөр хэвээр байна	22

Зураг I.9.	Ерөнхий инфляц Төв банкны инфляцын зорилтот түвшнээс дээгүүр хадгалагдаж байна	22
Зураг I.10.	Зээл олголт голлон хэрэглээний зээлд төвлөрч байна	24
Зураг I.11.	Активын чанар дорвитой сайжрахгүй байгаа нь арилжааны банкуудын зээл олгох сонирхлыг бууруулж байна.....	24
Зураг I.12.	Зээлийн өндөр хүү зээлийн өсөлтөд мөн нөлөөлөв.....	24
Зураг I.13.	Төсвийн нийт зардал эргэн өссөн	25
Зураг I.14.	... тэр дундаа, төрийн албан хаагчдын цалин, хөрөнгө оруулалтын зардал илүүтэй нэмэгдлээ.....	25
Зураг I.15.	2023 онд төсвийн орлогын бүрдүүлэлт сайн байгаа нь	26
Зураг I.16.	...эдийн засгийн сэргэлт, гадаад худалдаа идэвхэжсэнтэй нийцтэй байна.....	26
Зураг I.17.	Төсвийн тэнцэл ихээхэн сайжирч байна	28
Зураг I.18.	Экспорт өсөж урсгал дансны тэнцэл ашигтай гарахад голлон нөлөөлөв	29
Зураг I.19.	Нүүрсний экспорт нэмэгдэж нийт экспортын орлогын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлжээ.....	29
Зураг I.20.	Хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой түлш, капитал бараа, бүтээгдэхүүний импорт нэмэгджээ.....	29
Зураг I.21.	Зэс баяжуулах уурхайд шаардагдах хөрөнгө оруулалт буурч, олон улсын санхүүгийн зах зээл дээрх тодорхой бус байдал үргэлжилснээр ГШХО-ын дотогшлох урсгал удааширсан	30
Зураг I.22.	... гэсэн ч экспорт эрчимжиж, зарим гадаад өр төлбөрүүдийг дахин санхүүжүүлснээр гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд дэм боллоо	30
Зураг Ш.3.	Энэ онд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын зах зээлд Монголын эзлэх хувь нэмэгдсэн.....	31
Зураг Ш.4.	...гэвч бусад нүүрс экспортлогчдоос харьцангуй хямд нийлүүлжээ	31
Зураг I.23.	Монгол улс макро эдийн засгийн өндөр эрсдэлтэй тулгарч байгаа ч түүнд хариу өгөх төсвийн орон зай хомс байна.	35
Зураг Ш.5.	Монгол нь нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалтаар өндөр орнуудын нэг юм.	36
Зураг Ш.6.	Монголын нүүрсийг голлон импортлогч Хятад улс нүүрсний хэрэглээг үлэмж бууруулах төлөвтэй.	36
Зураг II.1.	2022 оны байдлаар Монгол Улсад олон төрөлт үйлчилгээ үзүүлдэг болон программ хангамжийн хөгжүүлэлт эрхэлдэг компаниуд орлогоороо дээгүүр жагсаж байна.....	39
Зураг II.2.	Ижил төстэй бүтэц бүхий улс орнуудтай харьцуулахад Монгол Улс МХХТ-ийн үйлчилгээний экспортоор хоцрогдолтой байна.	39
Зураг II.3.	Монгол Улсын кибер аюулгүй байдал сул байна	40
Зураг II.4.	Ажил олгогчдын хувьд хангалттай ур чадвар бүхий техникийн мэргэжилтэн олоход хүндрэлтэй байна.	41
Хүснэгт		
Хүснэгт Х.1.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	10
Хүснэгт I.2.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕХ	Европын холбоо
ЗАНД	Зүүн Ази, Номхон Далайн бүс
ИӨС	Ирээдүйн өв сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
МУЭЗТ	Монголын эдийн засгийн тойм
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУХХХ	Олон улсын харилцаа холбооны холбоо
ОТ	Оюу толгой
СЯ	Сангийн яам
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТСТС	Төсөв, санхүүгийн тойм судалгаа
ТТ	Төлбөрийн тэнцэл
ТЭС	Төсвийн тогтворжуулалтын сан
УБ	Улаанбаатар хот
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага
ЭХМД	АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн алба
ХМХ	Хүүхдийн мөнгө хөтөлбөр
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ШСБ	Шинэ сэргэлтийн бодлого

ТАЛАРХАЛ

Монголын эдийн засгийн тоймын энэ удаагийн дугаарыг ахлах эдийн засагч Хосе Луис Диаз Санчез, эдийн засагч Батмөнхийн Ундрал, зөвлөх Энхтуяагийн Дулмаа, Залуу мэргэжилтэн хөтөлбөрийн оролцогч Анна Твум нар бэлтгэв. Тоймын хоёрдугаар бүлэгт Дэлхийн Банкнаас удахгүй эрхлэн гаргах гэж буй “Монгол улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын шинжилгээ” тайлангаас хураангуйлан өгүүлэв. Тоймыг Дэлхийн Банкны БНХАУ, Монгол Улс, БНСУ-ыг хариуцсан захирал хатагтай Мара К. Варвик, Макро эдийн засаг, төсвийн асуудал хариуцсан менежер ноён Себастьян Экардт, Монгол Улс дахь суурин төлөөлөгч ноён Таэхун Ли нарын удирдлага дор бэлтгэв. Тайлан бэлтгэхэд туслалцаа үзүүлэн хамтарч ажилласан гадаад харилцаа хариуцсан ажилтан Болд-Эрдэнийн Жавхлан, туслах ажилтан Төмөрийн Сүхчимэг нарт багийн зүгээс талархал илэрхийлж байна.

Энэхүү тоймд тусгасан Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн дүгнэлт, тайлбар нь Дэлхийн Банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөл эсвэл тэдний төлөөлж буй Засгийн газрын байр суурийг илэрхийлэх албагүй болно. Дэлхийн Банк болон Монгол дах үйл ажиллагааны талаарх мэдээллийг <https://www.worldbank.org/en/country/mongolia> холбоосноос авч болно. Энэхүү тоймтой холбоотой санал, шүүмжээ Батмөнхийн Ундралд ирүүлнэ үү (ubatmunkh@worldbank.org). Тоймд ашигласан тоо, мэдээллийн хамрах хугацааг 2023 оны есдүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгов.

ХУРААНГУЙ

Бүлэг I: Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв

1.1 Эдийн засгийн өнөөгийн байдал

Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж буй хэдий ч жигд бус, уул уурхайн салбарт голлон түшиглэсэн бөгөөд уул уурхайн бус салбарын идэвхжил сул байна (Зураг Х.1). 2022 онд 5 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 2023 оны эхний хагас жилд 6.2 хувьд хүрч эрчимжээд байна. Урьдчилсан гүйцэтгэл, тэр дундаа уул уурхайн салбарын тоон мэдээллээс үзэхэд энэхүү хандлага гуравдугаар улиралд ч мөн адил хадгалагджээ. Эдийн засгийн өсөлт ийнхүү эрчимжиж байгаа ч тэнцвэргүй, уул уурхайн салбар эдийн засгийн сэргэлтэд голлох үүргийг гүйцэтгэсээр байна. Тодруулбал, 2023 оны эхний хагасын эдийн засгийн өсөлтийн 90 орчим хувийг уул уурхайн үйлдвэрлэл болон экспортод гаргах тээврийн үйлчилгээ дангаараа бүрдүүлжээ. Цар тахлын холбогдолтойгоор БНХАУ руу гарах нүүрсний экспортод тавьж байсан хилийн хязгаарлалтууд суларснаас голлон шалтгаалж нүүрсний олборлолт 2023 оны эхний гурван улиралд өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 3 дахин тэлээд байна. Түүнчлэн, Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлсэнтэй холбогдуулан зэсийн олборлолт оны эхний гурван улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 19.9 хувиар өсжээ. Харин цар тахлын дараа ажиглагдаж байсан үйлчилгээний салбарын эрчтэй сэргэлт энэ онд удааширч, цаг агаарын хүндрэлээс шалтгаалан хөдөө аж ахуй (ХАА)-н салбарын үйлдвэрлэл агшсан зэрэг нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт харьцангуй сул байна.

Эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас гадаад эрэлт, төсвийн зардал тэлж байгаа зэрэг нь голлон тайлбарлаж

байгаа бол хувийн хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөө бага байв. БНХАУ руу экспортлох нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдсэнээр цэвэр экспорт энэ оны эхний хагас жилийн эдийн засгийн өсөлтийг голчлон тайлбарлаж байна. Үүнээс гадна, төрийн байгууллагын хэрэглээ болон улсын хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг ихээр тэтгэх нөлөө үзүүлжээ (Зураг Х.2). Гэвч гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал бага, арилжааны банкнууд ААН-үүдэд бизнесийн зээл олгохдоо болгоомжилсон хандлагатай байж, улмаар зээлийн нөхцөл хатуу байгаатай холбогдуулан хувийн хөрөнгө оруулалт (үүнд төрийн өмчийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг оруулаад) агшсан тооцоолол гарч байна.

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил сул хэвээр, ХАА-н үйл ажиллагаанаас олох өрхийн орлого буурч, өндөр инфляц бодит орлогын түвшинд нөлөөлснөөр хувийн хэрэглээний өсөлт харьцангуй хязгаарлагдмал байв. Ажилгүйдлийн түвшин түүхэн доод түвшин буюу 5-6 хувь орчимд 2022 оны дунд үеэс хойш хадгалагдаж байгаа боловч 2023 оны эхний хагас жилд нийт ажил эрхлэлтийн өсөлт зогсонги болж, ажиллах хүчний оролцооны түвшин цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил сул хэвээр байгааг илэрхийлж байна. Түүнчлэн, цалин хөлсний орлого өссөн хэдий ч ХАА-н үйлдвэрлэл саарсантай холбогдуулан өрхийн ХАА-н үйл ажиллагаатай холбоотой орлого буурсан төдийгүй инфляц хоёр оронтой өндөр түвшинд хадгалагдсанаар өрхийн бодит орлогод мөн сөргөөр нөлөөлжээ. Улмаар

2023 оны эхний хагас жилийн байдлаар бодит орлого буурч, хувийн хэрэглээний өсөлтийг хязгаарлах нэг нөхцөл болжээ. Харин 7 сараас мөрдөгдөж буй 2023 оны төсвийн тодотголд тусгагдсан өрхүүдийн орлогыг дэмжих арга хэмжээ гуравдугаар улирлаас эхлэн хувийн хэрэглээг дэмжих нөлөө үзүүлэхээр байна.

Импортын барааны үнэ алгуур буурч байгаа хэдий ч эрэлтийн гаралтай үнийн дарамт хуримтлагдаж, инфляц өндөр түвшинд хэвээр байна. Худалдааны томоохон хилийн гарцууд дагуу нийлүүлэлтийн саатал үүсэж, тээврийн зардал нэмэгдэн, олон улсын зах зээл дээр эрчим хүчний болон хүнсний үнэ огцом өссөнөөс гадна нэрлэсэн валютын ханш суларсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үнийн дарамт бий болж, улмаар 2022 оны эцэст инфляц 13.3 хувьтай байсан. Дээрх гадаад хүчин зүйлсийн нөлөө энэ онд аажмаар арилж, 9 сард 10.1 хувьд хүрч буураад байна. Гэвч ХАА-н үйлдвэрлэл саарч, нийлүүлэлтийн хомсдол үүссэнтэй холбогдуулан дотоодод үйлдвэрлэгдсэн хүнсний үнэ тогтмол өсөж, улмаар инфляц өндөр түвшинд хадгалагдах нэг нөхцөл болж байна. Сүүлийн үед авч хэрэгжүүлж буй төсвийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний нөлөөгөөр эрэлт талаас үнийн дарамт улам нэмэгдэх боломжтой юм (Зураг Х.3). Төсвийн тодотголоор оруулж ирсэн иргэдийн орлогыг дэмжих арга хэмжээний нөлөөгөөр үүсэж болзошгүй эрэлтийн гаралтай инфляцын дарамтаас болгоомжлон Төв банк бодлогын хүүгээ сүүлийн 6 жилийн хамгийн өндөр түвшинд хэвээр хадгалж байна.

Арилжааны банкнууд эрсдэл багатай хэрэглээний зээлийг түлхүү олгон, бизнесийн болон ипотекийн зээл олголтыг хязгаарлаж байсан тул зээлийн өсөлт удаашралтай байна. Цалин, тэтгэврийн орлого, хадгаламж барьцаалсан хэрэглээний зээл хурдацтай өсөж, улмаар нийт зээлийн өсөлтийг голчлон

тодорхойлж байна. Харин хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд дуусгавар болж, арилжааны банкнууд энгийн нөхцөлөөр ААН-үүдэд шинээр зээл олгохоос аль болох болгоомжлон, активын чанараа муутгах эрсдэлээс сэргийлж байгаатай холбогдуулан 2023 оны туршид бизнесийн зээлийн өсөлт маш сул байлаа (Зураг Х.4). Үүнээс гадна, Засгийн газар эсхүл төрийн өмчийн аль нэг байгууллагад Монголбанкнаас ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг шилжүүлэх талаар тодорхой бус байдал үүссэнтэй холбогдуулан уг хөтөлбөрийн хүрээнд зээл олголт түр хумигдаад байв. Мөн зээлжих өртөг өндөр байгаа нь хувийн хэвшлийн зээл авах эрэлтэд сөргөөр нөлөөлсөн байхаар байна.

Төсвийн зарлага нэмэгдсэн хэдий ч уул уурхайн салбараас орох орлого илүү давамгайлснаар улсын нэгдсэн төсөв ашигтай гарч байна. 2023 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, халамжийн хөтөлбөрүүдэд зориулагдсан нэмэлт зарлагыг тусгасан төдийгүй хүүхдийн мөнгө хөтөлбөрт бүх хүүхдийг эргүүлэн хамруулсан нь төсвийн нийт зарлага ДНБ-д эзлэх хувиар тэлэх гол үндэслэл болсон юм. Түүнчлэн, хэд хэдэн хүлээгдэж байсан төслүүдийг тэргүүн ээлжид дуусгахаар Засгийн газраас баримталсан бодлогын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын зардал мөн нэмэгдсэн (Зураг Х.5). Нөгөөтээгүүр, уул уурхайн салбар, тэр дундаа нүүрсний борлуулалтаас төвлөрөх орлого бүрдүүлэлт сайн байж, эдийн засгийн идэвхжил эрчимжсэнтэй холбогдуулан төсвийн орлого ДНБ-д эзлэх хувиар огцом тэлсэн. Энэ нь цаашлаад төсвийн тэнцэл 2023 оны эхний 9 сарын сарын байдлаар 2007 оноос хойших хамгийн өндөр түвшинд ашигтай гарах, улсын өр ДНБ-д эзлэх хувиар буурах нөхцөлийг тус тус бүрдүүлээд байна (Зураг Х.6). Гэвч гадаад өрийн түвшин өндөр хэвээр, Засгийн газрын өөрийн гаргасан болон баталгаа гаргасан бондуудын эргэн төлөлтийг хийхэд гадаад санхүүжилтийн

хэрэгцээ их байгаа нь төсвийн эрсдэл, гадаад хүчин зүйлд өтрөх эмзэг байдал хадгалагдсаар байгааг илэрхийлж байна.

Хөрөнгийн орох урсгал бага байсан ч экспорт сэргэснээр төлбөрийн тэнцлийн урсгал дансашигтай гарч, гадаад валютын нөөц хуримтлалд эергээр нөлөөлжээ. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан хэдий ч түүхий эдийн экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрээд байна (Зураг Х.7). Үүнд (i) цар тахалтай холбогдолтойгоор тавьж байсан худалдааны хязгаарлалтуудыг цуцалсан, (ii) БНХАУ-тай хилийн ойролцоо төмөр замын шинэ бүтээн байгуулалтууд хийгдээд байгаа төдийгүй БНХАУ-д нүүрсний эрэлт огцом өссөн, (iii) Оюу толгойн далд уурхайгаас олборлож буй зэсийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн

Эдийн засгийн хэтийн төлөв, эрсдэл, бодлогын зөвлөмж

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд эрчимжиж, 2024 онд 6.2 хувьд хүрэх төлөвтэй байна. Оны эхний хагаст ажиглагдсан эдийн засгийн идэвхжлийн эрч хадгалагдснаар 2023 оны эдийн засгийн өсөлт 5.8 хувьд хүрэх төсөөлөлтэй байна (Хүснэгт Х.1). Цаашид нүүрсний экспорт болон хувийн хэрэглээний өсөлт хүлээлтээс өндөр байх тохиолдолд энэ оны өсөлт төсөөллөөс өндөр гарч болзошгүй. Харин ирэх жил хувийн хэрэглээ болон төсвийн зардал голлон тэлж, эдийн засгийн өсөлтийг тэтгэх нөлөө үзүүлэхээр байна. Нийлүүлэлт талаас уул уурхайн салбарын үйлдвэрлэл үргэлжлэн өсөх хүлээлттэй байгаа бол ХАА-н үйлдвэрлэл энэ оны уналтыг даваад эргээд сэргэх, хувийн хэрэглээ нэмэгдсэнээр үйлчилгээний салбаруудын өсөлт эрчтэй байх төлөвтэй байна. Төсвийн зардал үргэлжлэн тэлж, улмаар дотоод эрэлт сэргэх нөлөөгөөр эрэлтийн гаралтай үнийн дарамт үүсэхээр байгаа хэдий ч олон улсын зах зээл дээр хүнс болон шатахууны үнэ буурах, дотоодод мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн баримтлана гэж үзвэл 2024 онд инфляц дунджаар 9.1 хувьд хүрч буурах таамаглалтай байна. Уул уурхайн салбараас

зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Нөгөөтээгүүр, олон улсын зах зээл дээр хүнс, эрчим хүчний үнэ алгуур буурч байгаа нь импортын зардал харьцангуй бага байх нөхцөлийг бүрдүүлэв. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтад шаардагдах санхүүжилт буурснаас гадна уул уурхайн бус салбарт чиглэсэн хөрөнгийн орох урсгал харьцангуй бага байсан тул ГШХО цар тахлын өмнөх түвшнээс мэдэгдэхүйц доогуур хэмжээнд хадгалагдаж байна. Гадаад валютын нөөц хуримтлагдсаар 2023 оны 9 сарын эцэст сүүлийн 20 сарын хамгийн өндөр түвшин буюу 4.1 тэрбум ам.долларт хүрээд байгаа хэдий ч энэ нь дөнгөж 3.7 сарын валютын төлбөртэй импортын хэрэгцээг хангахуйц байна (Зураг Х.8).

төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2023 онд огцом нэмэгдсэн ч 2024 онд энэ эрчээр дахин нэмэгдүүлэхэд хүндрэлтэй. Нөгөө талаас мөчлөг дагасан төсвийн тэлэх бодлогыг 2024 онд үргэлжлүүлснээр зардал орлогыг давамгайлах тул одоогоор ашигтай байгаа төсвийн тэнцэл эргэн алдагдал руу шилжихээр байна. Энэ жил огцом сэргээд буй экспортын орлого цаашид тогтворжиж, дотоод эрэлтийг дагаад импортын зардал эрчимжих, олон улсын хөрөнгийн зах зээлийн орчноос шалтгаалан Монгол Улсыг чиглэх гадаад хөрөнгийн орох урсгал хязгаарлагдмал хэвээр байх зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан төлбөрийн тэнцлийн дарамт 2024 онд дахин бий болох хүлээлттэй байна.

Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил эрчимтэй хэвээр байна. Тодруулбал, 2025-2026 онуудад эдийн засгийн өсөлт дунджаар 6.3 хувьд хүрэхээр төсөөлж байна. Үүнд Оюу толгой уул уурхайн үйлдвэрлэл 2025 он гэхэд энэ оны түвшнээс 2 дахин нэмэгдэж, 2026 онд үргэлжлэн өндөр түвшинд хадгалагдах хүлээлт голлох үндэслэл болов. Ирэх оны УИХ-ын сонгуулийн дараа төсвийн зардлын

өсөлт тогтворжиж, улмаар уул уурхайн салбараас төвлөрөх орлогоор төсвийн алдагдлыг хумих, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахад дэмжлэг болно гэж тооцоолж байна.

Эдийн засгийн хэтийн төлөвт нөлөөлж болзошгүй эрсдэлүүд сөрөг талдаа давамгайлж байгаа бол голчлон уул уурхайн салбартай холбогдох зарим зэрэг тодорхой бус хүчин зүйлсийг мөн онцолж болно. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх (үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт удаан хугацаанд сунжрах шалтгаанаар), өмнө байгуулсан оффтейк гэрээнүүдийн хүрээнд нүүрсний экспортын орлого орж ирэх хугацаанд нөлөөлөх зэрэг хүчин зүйлс Монгол Улсын эдийн засаг, ялангуяа нүүрсний экспортын төлөвт томоохон сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй. Сонгуулийн өмнө хүлээгдэж байгаагаас илүү их хэмжээгээр төсөв тэлсэн тохиолдолд инфляцын дарамтыг улам дэвэргэж, импортын эрэлтийг нэмэгдүүлэн, улмаар урсгал данс болон төсвийн “хос” алдагдлыг тэлж болзошгүй юм. Үүнээс гадна Ойрхи Дорнод дахь геополитикийн хурцадмал байдлын улмаас газрын тосны үнэ ихээхэн өсөж, улмаар гадаад тэнцэл, дотоодын шатахууны үнэд нөлөөлөх эрсдэл бий. Харин дотоодын төмөр замын сүлжээг экспортын тээвэрлэлт хийх зорилгоор БНХАУ-ын талтай холбох гэх мэт мега төслүүдийг хурдацтай хэрэгжүүлэн дуусгах, Оюу толгой далд уурхайн үйлдвэрлэлээ хүлээгдэж байснаас эрт, их хэмжээгээр тэлэх, түүхий эдийн үнэ хүлээлтээс өндөр байх зэрэг хүчин зүйлс уул уурхайн экспортод эергээр нөлөөллөнө. Түүнчлэн, саяхан тохиролцоонд хүрээд буй Орано уран олборлох төслийн явц хурдацтай урагшилсан тохиолдолд дунд хугацаанд ГШХО-ын орох урсгалыг төсөөлж байгаагаас илүү нэмэгдүүлнэ.

Түүхий эдийн мөчлөлийг дагасан энэ оны эдийн засгийн эрчимтэй сэргэлтийг ашиглан төсвийн хуримтлалыг дахин бүрдүүлэх, гадаад валютын нөөц

боллоцгоог нэмэгдүүлэх, улмаар тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, бэхжүүлэх нэг боломж бүрдэж байна. Богино хугацаанд эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулахын тулд төсвийн зарлагыг зохистой удирдах замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх чиглэлээр төв банкны хамт хүчин чармайлтад дэмжлэг болох боломжтой. Дунд хугацаанд Ирээдүйн өв санд хуримтлуулах дүрмийг сэргээн мөрдөж, төсвийн хуримтлалыг дахин бүрдүүлснээр цаашид болзошгүй сөрөг нөлөөлөлд Засгийн газраас хариу арга хэмжээ авах, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг ирээдүйд шаардагдах хөрөнгө оруулалтад санхүүгийн орон зай үлдээх боломжийг бий болгоно.

Уул уурхайн салбарт хэт тулгуурлан, эдийн засаг жигд бус сэргэж байгаа нь уур амьсгал болон хөгжлийн өнөө үед тулгарч буй сорилтуудыг улам хүндрүүлж байгаа төдийгүй эдийн засгийг төрөлжүүлэх бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн арга хэмжээг сэргээн авч хэрэгжүүлэх ач холбогдлыг тодотгож байна. Энэ жилийн хувьд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт огцом тэлж, макро эдийн засгийн нөхцөл байдал сайжрахад дэмжлэг болж байгаа хэдий ч Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, түүхий эдийн мөчлөгийн хэлбэлзлийг тэсвэрлэх чадамжийг бэхжүүлэхэд чиглэсэн бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд эдгээр эерэг өөрчлөлтүүд зөвхөн богино хугацаанд ажиглагдаад өнгөрч болзошгүй юм. Түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дотоод болон олон улсын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх хүчин чармайлтыг улам гүнзгийрүүлэх, тэр дундаа ирээдүйд дэлхий нүүрсний хэрэглээнээс татгалзах шилжилтийн үйл явцад бэлтгэх шаардлага бий.

Хүснэгт Х.1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2021	2022	2023 төс	2024 төс	2025 төс	2026 төс
ДНБ-ий бодит өсөлт, зах зээлийн зэрэгцүүлэх үнээр	1.6	5.0	5.8	6.2	6.4	6.1
Хувийн хэрэглээ	-5.9	8.1	5.7	11.3	4.5	6.3
Төрийн байгууллагын хэрэглээ	9.2	6.9	13.6	11.3	1.8	3.4
Үндсэн хөрөнгийн хуримтлал	17.7	13.2	7.0	15.4	1.7	7.5
Бараа болон үйлчилгээний экспорт	-14.6	32.3	42.3	3.6	20.3	6.3
Бараа болон үйлчилгээний импорт	13.6	29.1	16.8	18.4	15.4	9.2
ДНБ-ий бодит өсөлт, үйлдвэрлэгчийн зэрэгцүүлэх үнээр	0.4	4.2	5.8	6.2	6.4	6.1
Хөдөө аж ахуй	-5.5	12.0	-10.7	11.5	5.0	6.5
Аж үйлдвэр (уул уурхайг оруулснаар)	-2.2	-4.5	13.6	5.0	11.3	9.4
Үйлчилгээ	3.9	6.9	6.9	5.4	4.0	4.0
Инфляц (ХҮИ, жилийн дундаж)	7.1	15.2	10.2	9.1	9.0	8.7
Урсгал дансны тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	-13.4	-13.4	-2.1	-13.7	-9.3	-10.5
ГШХО-ын цэвэр орох урсгал (ДНБ-д эзлэх хувь)	13.1	14.1	7.9	8.2	8.5	8.6
Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	-3.0	0.7	0.5	-2.4	-0.6	-1.1
Улсын өр (ДНБ-д эзлэх хувь)	64.5	62.2	52.3	52.0	50.5	49.6
Төсвийн анхдагч тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	-1.1	2.1	2.3	-1.0	0.7	0.1

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Тэмдэглэл: Улсын өрийн тооцоололд болзошгүй өр төлбөр буюу Монголбанкны Хятадын Ардын Банктай байгуулсан свот хэлцэл (2022 оны байдлаар ДНБ-ий 10 хувьтай тэнцэх)-ийн дүнг оруулаагүй болно.

Бүлэг II: Цахим үйлчилгээний салбар дахь худалдааны боломж

Дэлхий дахинд цахим худалдаа эрчимтэй өргөжиж байгаа нь Монгол Улсад далайд гарцгүй байдлаас шалтгаалан үүсдэг логистикийн бэрхшээлийг даван туулах, эдийн засгаа төрөлжүүлэх нэг боломжийг нээж байна. Дэлхий дахинд программ хангамж хөгжүүлэх, бизнесийн зарим үйл ажиллагааг гаднын этгээд болон компанид даатгаж хийлгүүлэх (аутсорсинг), цахим

худалдаа, финтекийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн технологи ашиглан эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг зайнаас хүргэх зэрэг чиглэлээр эрэлт өндөр байгаа нь Монгол Улсад цахим үйлчилгээний худалдаагаа өргөжүүлэх бололцоог нээж байна. Ярилцлага болон түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд программ хангамж хөгжүүлэлт, харилцаа холбоо болон цахим

сурталчилгааны чиглэлээр цахим үйлчилгээ үзүүлэх давуу тал Монгол Улсын хувьд оршиж байна. Салбартаа тэргүүлж буй компаниуд эдгээр чиглэлийг аль хэдийн онилж, ирээдүйд өсөж дэвших цар хүрээ болон инновацын потенциалыг олж харсан байна (Зураг Х.9).

Сүүлийн жилүүдэд цахим шилжилтэд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч Монгол Улс МХХТ-ийн үйлчилгээг хил дамнан үзүүлэх экспортын хувьд ижил төстэй улс орнуудтай харьцуулахад маш доогуур гүйцэтгэлтэй байна. Монгол Улс цахим шилжилтийн индексээр С-ангилалд багтсан хэвээр байгаа нь МХХТ-ийн дэд бүтэц, үйлчилгээний өртөг, бизнесийн орчин, ур чадвар, инновац, нийгмийн хүртээмжийн чиглэлд томоохон сорилтуудтай тулгарч байгааг илэрхийлж байна.¹ Түүнчлэн, Монгол Улсын МХХТ-ийн үйлчилгээний экспорт 2021 оны байдлаар ердөө 31.3 сая ам.доллар буюу ДНБ-ий 0.2 хувь, үйлчилгээний нийт экспортын 12 хувийг бүрдүүлж байна. Үүнтэй харьцуулахад Армени, Молдав зэрэг улс ДНБ-ий 3 орчим хувьтай тэнцэх цахим үйлчилгээг экспортолжээ. Тус салбарт эдгээр улс орнууд Монгол Улсаас илүү давуу талтай байгаа нь томоохон зах зээлтэй ойр байршдаг, чадварлаг ажиллах хүчний баазтай, интернэтийн холболт онцгой сайн, гадаад оршин суух нутаг нэгтнүүдийн сүлжээ цэцэглэн хөгжиж буй зэрэг хэд, хэдэн хүчин зүйлсээр тайлбарлагдаж байна.

Монгол Улсад харилцаа холбоо, интернэт нэвтрүүлэлтээр ахиц гарч байгаа ч цахим дэд бүтцийн хувьд томоохон саад бэрхшээлүүд тулгарсаар байна. Тухайлбал, сүлжээний хурд удаан төдийгүй кибер аюулгүй байдал бүрэн хангагдахгүй байна. Өндөр ур чадвартай ажиллах хүчний дутагдал цахим үйлчилгээний салбарт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, хууль, эрхзүйн зохицуулалт дутмаг байгаа нь тус салбарын хөгжлийг хойш татсаар байна.

Оюуны өмчийн болон мэдээлэл, өгөгдөл хамгаалах дүрэм журам, зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломж, шударга өрсөлдөөний бодлого, олон улсын мэдээллийн гарцад холбогдох боломж, мэдээлэл хамгаалал болон эрхзүйн орчны хувьд томоохон дутагдал ажиглагдаж байна. Гэтэл хөрөнгө оруулагчид цахим бизнесийн үйл ажиллагаанд шинээр хөрөнгө оруулахдаа өгөгдлийн аюулгүй байдал, оюуны өмчийн эрхийг хамгаалах зохиогчийн эрх болон мэдээллийн нууцлалын талаар хууль журам, эрхзүйн зохицуулалтад нарийн анхаарал хандуулдаг байна.

Цахим дэд бүтэц болон холболтыг сайжруулснаар цахим үйлчилгээний экспортыг дэмжих боломжтой. Мэдрэгч тус бүрийг шилэн кабелиар холбох гэх зэргээр харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулснаар интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний холболтын хоцролтыг, ялангуяа олон улстай хуурай газраар холбогдох сүлжээний хоцролтыг бууруулах ач холбогдолтой юм. Блокчейн технологийн тусламжтайгаар цахим үйлчилгээний экспортыг бүрэн шинэчлэх бололцоотой учраас Монгол Улс шаардлагатай туслах дэд бүтцэд хөрөнгө оруулах, үндэсний блокчейн сүлжээг байгуулах бодлогын арга хэмжээг боловсруулах боломжтой. Түүнчлэн, Сингапурын цахим эдийн засгийн түншлэлийн гэрээ (DEPA) болон Европын Холбоо – Сингапур хоорондын цахим түншлэл зэрэгтэй адил олон улсын түншлэл байгуулах, зах зээлийн нөхцөл байдлыг тандах цогц мэдээллийн сүлжээг бий болгох замаар цахим холболтыг сайжруулснаар ААН-үүдэд хил дамнасан мэдээлэлд саадгүй нэвтрэх боломж олгохоос гадна олон улсад цахим үйлчилгээг үзүүлэхэд мөрдөгдөж буй стандарт, хэм хэмжээг дотоодод сахин хэвшүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх юм.


¹ Нийт 100 оноо (хамгийн дээд оноо)-ноос 20-39 оноо авсан улс орнуудыг цахим шилжилтийн С-ангилалд хамруулдаг.

Цахим ур чадварыг дээшлүүлэх санаачилга гарган, үндэсний цахим хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх замаар өндөр нэмүү өртөг бүхий цахим салбарт хувийн хэвшлийн санаачилгыг хөхиүлэн дэмжиж болно. Зүүн өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (ALMIS), Персийн Булангийн хөдөлмөрийн зах зээлийн ажиглалтын төв, Колумбын ур чадварын зөвлөлийн ажиглалтын төв гэх зэрэг бэлэн санаачилгаас Монгол Улс санаа авч, цахим ур чадварын ажиглалтын төв байгуулах замаар цахим үйлчилгээний экспортод шаардлагатай ур чадварын дутагдал хэр байгааг тогтоох боломжтой. Үүний дараагаар эрэлт өндөр болох нь тогтоогдсон ур чадварыг олгох техникийн сургалт явуулах, ажлын байранд зуучлах зэрэг мэдлэг боловсрол дээшлүүлэх санаачилгуудыг авч хэрэгжүүлж болно.

Цахим үйлчилгээ үзүүлэхэд өгөгдөл чухал ач холбогдолтой хэдий ч цөөн хүн амтай учраас мэдээлэл өгөгдлийн цар хүрээ хязгаарлагдмал байдгийг харгалзан синтетик өгөгдлийг хөгжүүлэх, мэдээллийг солилцох эрхзүйн орчныг нь бүрдүүлэх замаар хувийн хэвшлийн санаачилгыг мөн дэмжих боломжтой. Эцэст нь цахим үйлчилгээ үзүүлэх гарааны бизнесүүдийн нэгдсэн экосистемийн хөгжилд чухал ач холбогдол өгөх шаардлагатай. Тодруулбал, зохицуулалт, эрхзүйн орчныг тодорхой болгохоос гадна гарааны шинэ бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийх, судалгаа болон хөгжүүлэлтийн үйл явцад татварын дэмжлэг үзүүлэх, тохиролцсон харьцааны дагуу санхүүжилтийг хуваан гаргах, гарааны бизнесийн хувьцаа эзэмшилд нөлөөлөхгүйгээр зээл олгох болон буцалтгүй тусламж үзүүлэх зэрэг олон төрлийн санхүүгийн тусламжийг үзүүлж дотоодын инновац, хөгжилд томоохон түлхэц болно.

Зураг Х.1. Эдийн засгийн өсөлт жигд бус бөгөөд өсөлтийн дийлэнхийг уул уурхайн, тэр дундаа нүүрсний олборлох үйлдвэрлэл, ...


Хуримтлагдсан ДНБ-ий жилийн өсөлт, үндсэн салбараар



Эх сурвалж Үндэсний статистикийн хороо (ҮСХ). Тэмдэглэл: БТ = баруун тэнхлэг.

Зураг Х.2... цэвэр экспорт болон төсвийн зардлын өсөлт тайлбарлаж байна.


ДНБ-ий өсөлтөд эрэлт талын бүрэлдэхүүний эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ.

Зураг Х.3. Дотоодод үйлдвэрлэгдсэн бараа, үйлчилгээний үнэ тогтмол өсөж, улмаар инфляц өндөр түвшинд хадгалагдан, өрхийн бодит орлогод сөргөөр нөлөөлж байна.


Инфляцад эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг Х.4. Хувийн хэвшилд олгож буй зээлийн өсөлт хязгаарлагдмал байгаа нь хувийн хөрөнгө оруулалтыг сааруулах нөлөө үзүүлж байна.


Хэрэглээний болон бизнесийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлээс тооцсон жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.

Зураг Х.5. Төсвийн нийт зарлага эргэн өсөж,...


Төсвийн зарлага, ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо. Тэмдэглэл: Бараа ажил үйлчилгээний зардалд төрийн албан хаагчдын цалин, гүйцэтгэл суурилсан санхүүжилтийн өртгийг оруулсан.

Зураг Х.6. ... уул уурхайн салбараас төвлөрөх орлогын өсөлтөөр санхүүжигдэж байна.


Төсвийн орлого, ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг Х.7. Экспортын хэмжээ огцом нэмэгдсэнээр урсгал дансны тэнцэл ашигтай гарч ...


Урсгал данс болон түүний бүрэлдэхүүн, ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк.

Зураг Х.8 ... хөрөнгийн орох урсгал бага байснаас үл хамааран гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэв.

Төлбөрийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувиар болон гадаад валютын нөөц, сая ам.доллороор



Эх сурвалж: Монголбанк.
Тэмдэглэл: БТ = баруун тэнхлэг.

Зураг Х.9. МХХТ-ийн салбарт олон төрөлт үйлчилгээ үзүүлэх болон программ хангамж хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд ашиг орлогоороо тэргүүлж байна...

МХХТ-ийн салбарт ашиг орлогоороо тэргүүлж буй ААН-үүдийн үзүүлж буй үйлчилгээний төрөл, нийт ААН-д эзлэх хувь



Эх сурвалж: Crunchbase өгөгдөлд суурилсан мэргэжилтний тооцоо.

Зураг Х.10. Монгол Улсын кибер аюулгүй байдлын үзүүлэлт сул байна.

Олон улсын кибер аюулгүй байдлын 2020 оны индекс үнэлгээгээр Монгол Улсын авсан оноо (дэд бүрэлдэхүүний нийлбэрээр авсан нийт оноо= 26.2/50)



Эх сурвалж: ХХОУХ-ны олон улсын кибер аюулгүй байдлын 2020 оны индекс.
Тэмдэглэл: Кибер аюулгүй байдлын гүйцэтгэлийг дээрх 5 хэмжээсээр үнэлдэг бөгөөд өндөр оноо нь гүйцэтгэл сайн байгааг харуулна.

1

ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ



Бүлэг I:

Эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв

1. Эдийн засгийн өнөөгийн байдал


1.1 Уул уурхайн салбар, төсвийн зардал тэлснээр эдийн засгийн өсөлт эрчимжив

Монголын эдийн засгийн өсөлт эрчимжиж байгаа ч жигд бус, уул уурхайн салбарт голлон түшиглэсэн, уул уурхайн бус салбарын идэвхжил сул байна. 2022 онд 5 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 2023 оны эхний хагас жилд 6.2 хувьд хүрч эрчимжээд байна. Сүүлийн саруудад шинэчлэгдсэн тоон мэдээллээс үзэхэд өсөлтийн энэхүү эрч гуравдугаар улиралд ч мөн хадгалагджээ. Гэхдээ эдийн

засгийн өсөлтийн хурд салбар бүрд жигд бус байгаа бөгөөд өнгөрсөн оны уналтаас хойш эрчимтэй сэргээд буй уул уурхайн салбар өсөлтийг голлон тайлбарлаж байна (Зураг I.1). Харин 2023 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн бус салбарын өсөлт удаашралтай байгаа нь цар тахлын дараах уг салбарын эрчимтэй сэргэлт саарсан, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл унасан зэрэг хүчин зүйлстэй холбоотой.

Зураг I.1. Уул уурхайн үйлдвэрлэл мэдэгдэхүйц тэлснээр эдийн засгийн өсөлт хурдсаж байна

Хуримтлагдсан ДНБ-ий жилийн өсөлт, үндсэн салбараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (ҮСХ).
Тэмдэглэл: БТ = баруун босоо тэнхлэг.

Нийлүүлэлт талаас эдийн засгийн өсөлтийг уул уурхайн олборлолт болон нүүрсний тээвэрлэлт голлон тайлбарлаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаарх эдийн засгийн жилийн өсөлтийн 90 орчим хувийг уул уурхайн салбарын идэвхжил болон экспортын барааг тээвэрлэх тээврийн үйлчилгээний огцом өсөлт бүрдүүлж байна. Гуравдугаар улирлын уул уурхайн салбарын тоон мэдээллээс харахад энэхүү хандлага сүүлийн саруудад ч хадгалагджээ. Тодруулбал, 2023 оны эхний гурван улирлын байдлаар нүүрсний олборлолт өмнөх оны мөн үетэй харьцуулахад бараг гурав дахин нэмэгдээд

байгаа бол 2019 оны мөн үеэс 43.5 хувиар өсжээ. Үүнээс гадна, энэ оны гуравдугаар сараас Оюу Толгой (ОТ)-н далд уурхайн үйлдвэрлэл эхэлснээр зэсийн баяжмалын олборлолт 2023 оны эхний гурван улиралд өмнөх оны мөн үеэс 19.9 хувиар өслөө (Зураг I.2). Харин тээврийн үйлчилгээний хувьд энэ оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлжээ. Тээврийн салбарын уг идэвхжилийн $\frac{3}{4}$ -ыг нүүрсний экспортын тээвэр дангаараа бүрдүүлэв.

Уул уурхайн олборлолт, тээврийн үйлчилгээнээс бусад салбаруудын идэвхжил сул байна (Зураг 1.3). Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдгээр салбаруудын нийт үйлдвэрлэл 0.7 хувиар өсжээ. Үүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 9.9 хувиар агшсан, боловсруулах, барилга зэрэг уул уурхайгаас бусад аж үйлдвэрийн салбаруудын үйл ажиллагаа харьцангуй зогсонги байгаа нь голлон нөлөөллөө. 2022/2023 оны өвөл, хаврын улиралд цаг агаарын нөхцөл байдал хүндэрсний улмаас өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ оны эхний хагас жилд шинээр хүлээн авсан төл малын тоо 27 хувиар бага, том малын зүй бус хорогдол бараг 18 дахин өндөр байна. БНХАУ-ын талаас цар тахалтай холбоотой эрүүл ахуйн шаардлагыг зөөлрүүлж,

Монгол Улсын зүгээс махны экспортод тавьж буй дийлэнх квотыг цуцалснаар 2023 оны эхний хагас жилд мах боловсруулах үйл ажиллагаа, ялангуяа, экспортын зориулалтын мах боловсруулалт огцом өсөж, биет хэмжээгээр өмнөх оны мөн үеэс 2 дахин нэмэгджээ.¹ Харин сүлжмэл эдлэл, арьс шир зэрэг бусад бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл ихээхэн саарав. Барилгын өртөг үргэлжлэн нэмэгдэж, ипотекийн зээлийн олголт удааширсантай холбогдуулан орон сууцны борлуулалт саарсны зэрэгцээ (1.3 хэсгийг үзнэ үү), 2022 онд эрчимжиж байсан төмөр замын бүтээн байгуулалт, Оюу толгойн далд уурхайн барилгын ажил энэ онд хумигдсанаар 2023 оны эхний хагас жилд барилгын салбарын өсөлт нам түвшинд байв.

Зураг 1.2. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлд нүүрсний олборлолт давамгайлж байна

2019 оны эхний 3 улиралтай харьцуулахад нүүрс, зэсийн баяжмал болон нийт уул уурхайн бодит үйлдвэрлэл




Эх сурвалж: YCX.

Тэмдэглэл: 2019 оны эхний 3 улирлын үйлдвэрлэлийн хэмжээг 100-тай тэнцүүлж индекслэв.

Зураг 1.3. Бусад салбарын өсөлт удаашралтай байна

Хуримтлагдсан ДНБ-ий жилийн өсөлт, үүнд үндсэн салбаруудын эзлэх хувь (нэгж хувиар)



Эх сурвалж : YCX.


¹ Дотоодын зах зээлд махны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийн хэлбэлзлийг бууруулах үүднээс Засгийн газар экспортын квот тогтоож ирсэн.

Гадаад эрэлт эрчимжиж, төсвийн зардал их хэмжээгээр тэлснээр эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас голлон тайлбарлаж байна (Зураг 1.4). 2023 оны эхний хагас жилд нүүрсний экспортыг дагаад тээврийн үйлчилгээний эрэлт өндөр, хөрөнгө оруулалтын зориулалттай машин, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага их байсны улмаас эдгээр бараа, үйлчилгээний импортын эрэлт өндөр байлаа. Гэсэн хэдий ч цэвэр экспорт эдийн засгийн нийт өсөлтийн 19.2 нэгж хувийг бүрдүүлэв. Энэ нь нүүрс тэргүүтэй экспортын барааны биет хэмжээ огцом тэлж, оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 113 хувиар өссөнтэй холбоотой байв (Зураг 1.5, хэсэг 1.5 болон шигтгээ 1.1-ыг үзнэ үү). Дотоод эдийн засгийн хувьд улсын сектор нийт эрэлтийг голлон тэтгэлээ. Төрийн байгууллагуудын бодит хэрэглээний өсөлт 2022 оны эхний хагас жилд 6.7 хувьтай байсан бол энэ оны эхний хагас жилд 18.9

хувьд хүртэл эрчимжжээ. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын бодит зардал (үүнд, төрийн өмчийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг оруулаагүй) өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өсөж, улмаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар ДНБ дэх нийт үндсэн хөрөнгийн хуримтлалын 41.2 хувийг бүрдүүлсэн тооцоололтой байна.²Зээл олгох нөхцөл чангарсны зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын сэргэлт удааширсантай холбоотойгоор хувийн хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байв. Арилжааны банкнууд бизнесийн зээл олгохдоо эрсдэлээс болгоомжилсон хандлагатай байж, зээлийн нөхцөлөө чанга хэвээр хадгалсан (1.3, 1.5 хэсгийг үзнэ үү) төдийгүй гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал сул байснаас шалтгаалан хувийн хөрөнгө оруулалт (төрийн өмчийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг оруулснаар) энэ оны эхний хагас жилийн байдлаар 6.3 хувиар буурсан тооцоололтой байна.³

Зураг 1.4. Гадаад эрэлт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн ...


ДНБ-ий өсөлтөд эрэлтийн талын бүрэлдэхүүний эзлэх хувь (нэгж хувиар)



Эх сурвалж: YCX.

Зураг 1.5. ... уул уурхайн бүтээгдэхүүний үнэ харьцангуй нам түвшинд байсан ч экспортын биет хэмжээ өслөө.⁴

2019 оны эхний 3 улиралтай харьцуулсан нүүрс болон зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнэ



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Хятадын Гаалийн ерөнхий газар (ГЕГ).

Тэмдэглэл: 2019 оны эхний 3 улирлын үнэ, биет хэмжээг 100-тай тэнцүүлж индекслэв.

² Гадаад худалдаа, төсвийн гүйцэтгэлийн сүүлийн саруудын урьдчилсан мэдээнээс харахад 2023 оны гуравдугаар улиралд экспорт, импорт, төрийн хэрэглээний өсөх хандлага хэвээр байна (1.4, 1.5 хэсгийг үзнэ үү).

³ Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж өмнөх оны мөн үеэс 27 хувиар бага төл мал хүлээн авснаар ХАА-н гаралтай эргэлтийн хөрөнгө буурч, улмаар энэ жил материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт огцом багасжээ.


⁴ 2023 оны эхний есөн сард нийт экспортын орлогын 74.5 хувийг нүүрс, зэсийн баяжмалын экспорт бүрдүүлсэн тул тэдгээрийн экспортыг сонгон харуулав.

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил сул хэвээр, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас олох өрхийн орлого буурч, өндөр инфляцаас шалтгаалан бодит орлогын түвшин багассан зэрэг нь хувийн хэрэглээний өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Ажилгүйдлийн түвшин 2022 оны дунд үеэс хойш 5-6 хувь орчим (түүхэн доод түвшин)-д хадгалагдаж байгаа хэдий ч нийт ажил эрхлэлтийн өсөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар зогсонги байдалд орж ажиллах хүчний оролцооны түвшин цар тахлын өмнөх үеийн 61 хувь орчимд хүрээгүй байна (Зураг 1.6).⁵ Цалин хөлсний орлого нэмэгдсэн боловч ажлын байр цөөн байсан тул өрхийн бодит орлого 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс буураад байна (Зураг 1.7) Түүнчлэн,

хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл саарсан нөлөөгөөр тус үйлдвэрлэлээс олох өрхийн орлого буурав. Үүний зэрэгцээ инфляц хоёр оронтой тоонд буюу өндөр түвшинд хадгалагдсанаар өрхийн бодит орлого буурч, хувийн хэрэглээний өсөлт бага түвшинд хадгалагдах нэг нөхцөл болжээ. Харин 2023 оны долоодугаар сараас эхлэн хэрэгжиж буй төсвийн тодотголын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр (ХМХ)-т бүх хүүхдийг эргэн хамруулах, тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ нь (1.4 хэсгийг үзнэ үү) гуравдугаар улирлаас хувийн хэрэглээг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Зураг 1.6. Хөдөлмөрийн зах зээлээс гарч буй хүн амын тоо нэмэгдэж байгаа нь зах зээлийн идэвхжилийг сулруулж байна.


Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: ҮСХ.

Зураг 1.7 Өндөр инфляц өрхийн бодит орлогыг сааруулах нөлөө үзүүлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлтөд эзлэх хувь (нэгж хувиар), хувийн бодит хэрэглээний өсөлт



Эх сурвалж: ҮСХ.

Тэмдэглэл: Өрхийн бусад орлогын дийлэнхийг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас олох өөрийн орлого бүрдүүлдэг. 2022 оны 1 дүгээр улирлыг дуустал Ковшид-19 цар тахлын хүрээнд өрхийн орлогыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байсан нь 2023 оны 1 дүгээр улирлыг дуустал өрхийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой орлого өмнөх оноос буурах суурь нөлөөллийг бий болгов.

⁵ ҮСХ-ны ажиллах хүчний судалгаанаас үзэхэд тэтгэвэр, жирэмсний шалтгаанаар хөдөлмөрийн зах зээлийг орхиж байгаа хүн амын тоо нэмэгдэж, ажиллах хүчний оролцоо нам түвшинд байна.

Шигтгээ I.1. Дэлхийн эдийн засгийн болон түүхий эдийн үнийн хандлага^а


Дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хандлага

Дэлхийн эдийн засгийн өсөлт цар тахлын дараа огцом сэргэж байсан ч энэ эрчээ алдаж байна. Өнгөрсөн онд 3.1 хувиар өсөөд байсан дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд 2.1 хувь болж буурах төлөвтэй. Инфляцын эсрэг эрчимтэй хэрэгжүүлж буй хөгжингүй орнуудын мөнгөний хатуу бодлого нь олон улсын санхүүгийн зах зээлийг хязгаарлаж, улмаар дэлхийн эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байна. Хөгжингүй орнууд бодлогын хүүгээ шат дараалан өсгөснөөр олон улсын санхүүгийн зах зээлд хүүгийн зөрүүнд нөлөөлж, улмаар хөгжиж буй, шинэ тутам эрчимтэй хөгжиж буй улс орнуудаас хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэхэд хүргэж байна. БНХАУ-ын эдийн засгийн хувьд хилээ бүрэн нээснээр 2023 оны эхний хагаст дотоод эрэлт тэлж, эдийн засгийн өсөлтөд түлхэц өгч байсан. Гэвч үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналтыг тойрсон болгоомжлол улам нэмэгдэж, оны сүүлийн хагаст эдийн засгийн өсөлт саарахаар байна. Монголын нүүрсний экспортын дийлэнх нь БНХАУ-ын барилга, гангийн үйлдвэрлэлд голчлон ашиглагддаг тул дээрх нөхцөл байдал нь Монгол улсын хувьд эрсдэл учруулж байна.

Дунд хугацаанд дэлхийн эдийн засгийн өсөлт ялимгүй эрчимжиж, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаахрах төлөвтэй байгаа тул хэтийн төлөв төдийлөн сайнгүй байна. Тухайлбал, 2024-2025 онуудад дэлхийн эдийн засгийн өсөлт 2.4, 3 хувьд тус тус хүрэх төсөөлөлттэй байгаа бол БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 4.4, 4.3 хувь болж удаахрах таамаглалтай байна (Зураг Ш.1). БНХАУ-ын дотоодын үл хөдлөх, аж үйлдвэрийн салбарын уналтаас шалтгаалан эдийн засгийн өсөлтийн төлөв хүлээгдэж байснаас саарах нөхцөл байдал үүсвэл бусад улс орнуудын, тэр дундаа Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөвт сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн, дэлхий даяар өндөр хүүгийн түвшин, санхүүгийн нөхцөл байдлыг тойрсон тодорхой бус байдал хадгалагдаж байгаа нь ГШХО-аас хамааралтай, макро эдийн засгийн эмзэг байдал өндөр улс орнуудын эдийн засгийн өсөлтөд дарамт учруулсан хэвээр байна. Үүнээс гадна, өрийн үйлчилгээний зардал нэмэгдэж байгаа нь шинэ тутам эрчимтэй өсөж буй улс орнуудын хувьд өрийн хямралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй. Мөн өндөр хөгжилтэй улс орнуудын банкны салбарт хүндрэл дахин бий болсноор зээл, хөрөнгө оруулалтын томоохон хямралыг өдөөж болзошгүй зэрэг сөрөг эрсдэлүүд байсаар байна.

Зураг Ш.1. Дэлхийн эдийн засгийн сэргэлт цар тахлын дараах эрчээ алдаж байна

Дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн өсөлт, хувиар




Эх сурвалж: Монгол, БНХАУ-ын Макро ядуурлын хэтийн төлөвийн тайлан (2023 оны 10 дугаар сар), Дэлхийн Банкны Дэлхийн эдийн засгийн төлөв (2023 оны 6 дугаар сар) тайлангаас бусад мэдээллийг авав.

Түүхий эд, таваарын үнийн төлөв байдал

Дунд хугацаанд олон улсын зах зээл дээр хүнс болон газрын тосны үнэ харьцангуй нам түвшинд хадгалагдах нь инфляцын дарамтыг зөөлрүүлэх хэдий ч уул уурхайн бүтээгдэхүүний экспортлогчдын орлого буурах төлөвтэй байна. Дийлэнх түүхий эдийн үнэ 2020-2022 оны туршид тасралтгүй өссөн. Харин нийлүүлэлтийн сүлжээний тасалдал арилж, дэлхийн зах зээл дээрх эрэлт харьцангуй саарснаа 2023 оны эхний гурван улирлын байдлаар голлох түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнэ өмнөх оны мөн үеэс 20 хувиар буураад байна.⁶ Олон улсын зах зээл дээр хүнсний болон газрын тосны үнэ харьцангуй нам түвшинд байж, инфляцын дарамтыг сулруулах нөлөө үзүүлж байгаа бол дийлэнх уул уурхайн бүтээгдэхүүн (коксжих нүүрснээс бусад)-ий үнэ буурч байгаа нь эдгээр түүхий эдийг экспортлогч орнуудын орлогод сөргөөр нөлөөлөв. Цаашид түүхийн эдийн үнэ буурч, 2025 оноос тогтворжих төлөвтэй (Зураг Ш.2). Дэлхийн эдийн засгийн өсөлт хүлээлтээс сул байх (тэр дундаа, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт огцом удаашрах), Ойрх Дорнод болон Зүүн Европ дахь геополитикийн хурцадмал байдал удаан үргэлжлэх зэрэг нь төсөөллийн онцлох эрсдэлүүд болж байна.

Зураг Ш.2. Түүхий эд, таваарын үнэ буурах хандлагатай байна

Зарим түүхий эд, таваарын үнэ, 2010 оны түвшнийг 100-тай тэнцүүлж индекслэв.



Эх сурвалж: Дэлхийн Банкны түүхий эдийн хэтийн төлөв (2023 оны 10 дугаар сар). Австралийн Засгийн газрын Аж үйлдвэрийн шинжлэх ухаан, нөөцийн департаментын металлургийн нүүрсний мэдээлэл (2023 оны 10 дугаар сар). Тэмдэглэл: Монгол улс голчлон коксжих нүүрс экспортолдог тул эрчим хүчний нүүрсний үнийг зураг оруулаагүй.

⁶ Энэхүү шигтгээнд Дэлхийн Банкаас бэлтгэн гаргадаг Дэлхийн эдийн засгийн төлөв (2023 оны 6 дугаар сар), Зүүн Ази, номхон далайн бүсийн эдийн засгийн тойм (2023 оны 10 дугаар сар), Түүхий эдийн төлөв (2023 оны 10 дугаар сар) тайлангуудын тооцоо шинжилгээ, төсөөллийг ашиглав.

1.2 Инфляц алгуур буурч байгаа ч өндөр түвшинд хадгалагдсаар байна

Импортын барааны үнийн өсөлт 2023 онд саарч, инфляцын дарамтыг бууруулж байна. Инфляц энэ оны есдүгээр сарын байдлаар 10.1 хувьд хүрээд байгаа нь өндөр түвшинд хэвээр тооцогдох ч өнгөрсөн оны эцэс дэх 13.2 хувийн түвшинтэй харьцуулахад алгуур буурсан хандлагатай байна. Цар тахал болон ОХУ-аас Украиныг эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаанаас

шалтгаалан Монгол улсын хилийн томоохон боомтуудад нийлүүлэлтийн саатал үүсэж, тээвэрлэлтийн өртөг нэмэгдсэний зэрэгцээ олон улсын зах зээл дээрх эрчим хүч болон хүнсний таваарын үнэ огцом өссөн, төгрөгийн ханш ихээр суларсан зэрэг хүчин зүйлсийн шалтгаантай инфляцын дарамт энэ онд мэдэгдэхүйц буурав. Үүний үр дүнд өнгөрсөн оны эцэст 13.4 хувьд хүрч байсан


⁶ Дэлхийн Банкны Түүхий эдийн үнийн мэдээлэл (2023 оны 10 дугаар сар) болон АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн алба (2023 оны 10 дугаар сар).

импортын бараа, бүтээгдэхүүний инфляц 2023 оны есдүгээр сарын байдлаар 7.4 хувьд хүрч саарлаа. Тодруулбал, олон улсын зах зээл дээрх нөхцөл байдалтай нийцтэйгээр

импортын хүнс болон түлшний үнэ энэ хугацаанд голчлон буурах (цөөн тохиолдолд ялимгүй өсөх) хандлагатай байв (Зураг I.8).⁷

Зураг I.8. 2023 онд импортын барааны инфляц буурсан ч дотоодод үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үнийн өсөлт өндөр хэвээр байна


Ерөнхий инфляцад эзлэх хувь



Эх сурвалж: YCX, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.9. Ерөнхий инфляц Төв банкны инфляцын зорилтот түвшнээс дээгүүр хадгалагдаж байна

Мөнгөний бодлогын хүү, инфляцын зорилт, ерөнхий инфляц



Эх сурвалж: YCX, Монголбанк.

Дотоодод үйлдвэрлэгдсэн хүнсний барааны үнийн өсөлт өндөр хэвээр хадгалагдаж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт эрчимжсэн тул инфляц өндөр хэвээр байна. Дотоодод үйлдвэрлэгдсэн бараа, үйлчилгээний инфляц өндөр хэвээр байгаа нь хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх ерөнхий инфляц өндөр түвшинд хадгалагдах гол нөхцөл болж байна. Тухайлбал, энэ онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл саарсантай холбогдуулан мах, гурил зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч (I.1 хэсгийг үзнэ үү), хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн өртөг нэмэгдсэнээр дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний үнэ эрчимтэй өслөө. Түүнчлэн хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, төсвийн зардал тэлснээр дотоод эрэлтийг нэмэгдүүлж, улмаар эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэж

байна (I.3 болон I.4 хэсгүүдийг үзнэ үү).

Төсвийн зарлагын өсөлтийг дагаад эрэлтийн гаралтай инфляцын дарамт эрчимжих эрсдэлийг харгалзан үзэж Төв банк бодлогын хүүгээ сүүлийн 6 жилийн хамгийн өндөр түвшинд хадгалж байна. Дээр дурдсанчлан инфляц аажмаар буурч байгаа ч 2023 онд дундаж ерөнхий инфляц Төв банкны “10 хувиас доош” байх зорилтот түвшнээс дээш буюу дунджаар 10.2 хувьд хүрэх төлөвтэй байна (Зураг I.9). Түүнчлэн, наймдугаар сард Төв банкнаас нийтэлсэн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаанаас харахад ирэх оны хоёрдугаар улирал хүртэл инфляц Төв банкны зорилтот түвшинд хүрч буурахгүй байх төлөвтэй байна. I.4 хэсэгт дурдсанчлан 2023 оны төсвийн тодотголд тусгасан төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн зардлын нэмэгдэл нь дотод эрэлтийг нэмэгдүүлэхээр

⁷ Өнгөрсөн онд ОХУ-ын экспортлогчидтой Монгол Улсын Засгийн газраас хийсэн хэлэлцээрийн үр дүнд өргөн хэрэглээний түлш, шатахууны үнэ харьцангуй тогтвортой байна.

байна. Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалж богино хугацаанд үнийн нэмэлт дарамт үүсэж болзошгүй тул Төв банкнаас 2023

оны туршид бодлогын хүүг 13 хувийн өндөр түвшинд хадгалж байна.

1.3 Арилжааны банкнууд зээлийн нөхцөлөө чанга хэвээр хадгалж, эрсдэлээс сэргийлэх бодлого баримталж байна

Эдийн засаг тогтвортой сэргэж байгаа ч арилжааны банкнууд эрсдэл багатай хэрэглээний зээлд төвлөрч, бизнесийн болон ипотекийн зээл олголтоо хумьж, зээлийн өсөлт сул байв. Өнгөрсөн оны 12 дугаар сард 3.9 хувьтай байсан зээлийн жилийн өсөлт энэ оны есдүгээр сарын байдлаар 13.7 хувьд хүрч эрчимжлээ. Гэвч энэ нь голчлон цалин, тэтгэвэр, хадгаламжийн орлогоор баталгаажсан хувийн хэрэглээний зээлийн эрчимтэй өсөлттэй холбоотой байна (Зураг I.10). Харин энэ оны туршид бизнесийн зээлийн өсөлт тун удаашралтай байж, дөрөвдүгээр сард бизнесийн зээл жилийн 1.1 хувиар агшив. Энэ нь 2021-2022 онуудад хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд дуусгавар болсноос гадна банкны хэвийн нөхцөлтэй бизнесийн зээлийг олгохоос зайлсхийх хандлага давамгайлж байгаатай холбоотой.⁸ Түүнчлэн, Монголбанкнаас Засгийн газарт орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг шилжүүлэхтэй холбоотойгоор тодорхой бус байдал үүссэний улмаас энэ оны хоёроос долоодугаар саруудын хооронд арилжааны банкнууд ипотекийн хөнгөлөлттэй зээл олголтоо бууруулсан. Улмаар дээрх хугацаанд барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн өсөлт дунджаар жилийн 1 хувиас доогуур түвшинд байв.

Активын чанар муудах эрсдэлээс сэргийлж арилжааны банкнууд бизнесийн зээлийн өсөлтийг хязгаарлав.


Монголбанкны статистик тоон мэдээллээс харахад 2023 оны эхний есөн сарын дунджаар нийт асуудалтай зээл (хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийлбэр) нийт зээлийн багцын 14.7 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ялимгүй буурсан үзүүлэлт болж байна (Зураг I.11). Гэвч, уул уурхай, боловсруулах, барилгын салбаруудын хувьд нийт зээлийн багцын харгалзан 34, 18, 20 хувийг чанаргүй зээл эзэлж байгаа нь тус салбаруудад бизнесийн зээлийн чанар асуудалтай байгааг илэрхийлж байна.⁹ Ийнхүү нийт асуудалтай зээлийн багц төдийлөн сайжрахгүй байгаагаас гадна 2021 онд Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд арилжааны банкнууд хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалах замаар банкны хувь эзэмшлийг төрөлжүүлж байгаа тул өөрсдийн тайлан тэнцэлд нөлөөлж болзошгүй өндөр эрсдэл үүрэх сонирхолгүй байна.

⁸ Арван их наяд хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 4.2 их наяд төгрөг, 2022 онд 2.6 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Харин 2023 онд арилжааны банкнууд ноолуурын салбарыг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 480 тэрбум төгрөгийн зээлийг олгожээ. Дээрх зээлд төрөөс баталгаа гаргаж, хүүгийн хөнгөлөлт үзүүлж байна.

⁹ Үүнтэй харьцуулахад хэрэглээ, ипотека, худалдааны салбарын зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь бага буюу 4-6 хувь орчимд байна.

Зураг I.10. Зээл олголт голлон хэрэглээний зээлд төвлөрч байна


Нийт зээл, хэрэглээний зээл, бизнесийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.11. Активын чанар дорвитой сайжрахгүй байгаа нь арилжааны банкнуудын зээл олгох сонирхлыг бууруулж байна

Нийт зээлийн үлдэгдэлд чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк.

Зээлжих зардал харьцангуй өндөр байгаа нь хувийн секторын зээлийн эрэлтийг хумьсан байх боломжтой. Өнгөрсөн онд инфляцын түвшин өндөр байж мөнгөний бодлогын хүүг шат дараалан нэмэгдүүлэх шаардлага үүссэн, үүнээс улбаалан арилжааны банкнуудын эх үүсвэр татах санхүүжилтийн өртөг, хадгаламжийн хүү нэмэгдэж, цаашлаад зээлийн хүү мөн өсөв. Арилжааны банкнуудын шинээр олгосон зээлийн хүү 2023 оны туршид алгуур өсөж есдүгээр сарын байдлаар 16.5 хувьд хүрлээ (Зураг I.12). Дээр дурдсан нөхцөлөөс гадна энэ онд хөнгөлөлттэй хүүтэй олгох зээлийн хэмжээ багассанаар шинээр олгосон зээлийн дундаж хүү өмнөх жилүүдээс өндөр тогтох нэг шалтгаан боллоо.

Зураг I.12. Зээлийн өндөр хүү зээлийн өсөлтөд мөн нөлөөлөв

Бодлогын хүү, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү, шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк.

1.4 Төсвийн тэнцэл сайжирсан ч гадаад сөрөг нөлөөлөлд өртөмтгий хэвээр байна

Төсвийн зардал нэмэгдсээр, тэр дундаа 2023 оны төсвийн тодотголтой холбогдуулан улам тэлжээ. Өнгөрсөн оны эхний есөн сарын байдлаар ДНБ-ий


22.7 хувиар хэмжигдэж байсан төсвийн нийт зардал энэ оны эхний есөн сарын байдлаар тухайн үеэс 18.2 хувиар тэлж ДНБ-ий 23.3 хувьтай тэнцэж байна (Зураг

1.13). Анх батлагдсан 2023 оны төсвийн хүрээнд төсвийн зардлыг харьцангуй бага хувиар өсөхөөр төсөвлөсөн бол энэ оны долоодугаар сарын эхнээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн төсвийн тодотголд ДНБ-ий 3.1 нэгж хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт зардлыг тусгасан. Уг нэмэлт зардлын талаас дээш хэсгийг төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг 10 хувиар нэмэх, даатгалгүй иргэдэд чиглэсэн халамжийн тэтгэмжийг 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээний зардлууд бүрдүүлж байна. ¹⁰ Мөн тодотголоор өнгөрсөн онд анх удаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зорилтот бүлгийн хүүхдэд олгох шийдвэрийг цуцлан, эргээд бүх хүүхдийг хамруулахаар шийдвэрлэсэн. Өмнөх шийдвэртэй холбогдуулан хүүхдийн

мөнгөн тэтгэмжээс 2023 оны эхний хагас жилд хасагдаад байсан нийт хүүхдийн 9 хувьд олгогдоогүй саруудын тэтгэмжийг нөхөн олгосон. Өнгөрсөн оны эхний есөн сарын байдлаар ДНБ-ий 4.0 хувьтай тэнцэж байсан төсвийн хөрөнгийн зардал энэ оны мөн үед 30.2 хувиар нэмэгдэж, ДНБ-ий 4.5 хувьд хүрчээ (Зураг 1.14). Цаашдаа 2023 оны эцэс гэхэд хөрөнгийн зардлыг ДНБ-ий 9 хувьд хүргэхээр төсөвлөсөн нь 2016 оноос хойших хамгийн өндөр дүнг илэрхийлж байна. Олон жил сунжирч буй хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэн дуусгах, Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт санхүүжилт олгох зэргийн шалтгаанаар төсвийн хөрөнгийн зардал ийнхүү тэлж байна.

Зураг 1.13. Төсвийн нийт зардал эргэн өссөн ...

Төсвийн зардал, ДНБ-ий хувиар




Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Тэмдэглэл: Бараа, үйлчилгээний зардалд гүйцэтгэлээр санхүүжүүлж буй зарим салбарын цалин, бусад зардлыг оруулав.

Зураг 1.14. ... тэр дундаа, төрийн албан хаагчдын цалин, хөрөнгө оруулалтын зардал илүүтэй нэмэгдлээ

Төсвийн зардлын жилийн өсөлт, үүнд зардлын бүрэлдэхүүний эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо. Тэмдэглэл: Бараа, үйлчилгээний зардалд гүйцэтгэлээр санхүүжүүлж буй зарим салбарын цалин, бусад зардлыг оруулав. Нийгмийн халамжийн шилжүүлэгт ХМХ-ийн зардлыг оруулсан.

¹⁰ Байнгын асаргаа шаарддаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд (хүүхэд, өндөр настныг хамруулан)-ийн асран хамгаалагч нарт олгох сарын тэтгэмжийн хэмжээг 3.25 дахин нэмэгдүүлснээр тус ангиллын зардал хамгийн их хэмжээгээр тэлсэн байна.


Ийнхүү тэлж буй төсвийн зардлыг уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлого хүлээлтээс давж, санхүүжүүлэх боломжтой байв.

Төсвийн нийт орлого 2023 оны эхний есөн сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 40.7 хувиар тэлж, ДНБ-ий 27.8 хувьд хүрээд байна (Зураг I.15, I.16). Дээрх хугацаанд уул уурхайн салбар (тэр дундаа, нүүрс, зэсийн баяжмалын олборлолт, экспорт) эрчимжсэнээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс бүрдүүлэх орлого огцом нэмэгдэж, төсвийн нийт орлогын 1/3-ийг бүрдүүлжээ. Мөн хугацаанд экспортын гол нэрийн түүхий эдийн үнэ тогтворжуулалтын жишиг үнээс өндөр байсан тул ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 17 орчим хувь

буюу ДНБ-ий 1 хувьтай тэнцэх орлогыг Төсвийн тогтворжуулалтын сан (ТЭС)-д хуримтлуулсан. Гэхдээ түүхий эдийн үнэ энэ онд буурах хандлагатай байсан тул уг сангийн хуримтлал өнгөрсөн оны мөн үеэс 43.4 хувиар буурчээ. Харин Ирээдүйн өв сан (ИӨС буюу өнөө болон ирээдүйн хойч үе хоорондын орлогыг тэнцвэржүүлэх баялгийн сан)-гийн зориулалтыг хэсэгчлэн өөрчилж, ХМХ-ийг үргэлжлүүлэн санхүүжүүлсэн тул уг сангийн хуримтлал харьцангуй хязгаарлагдмал байв.¹¹ Уул уурхайн салбараас бүрдүүлсэн орлогоос гадна эдийн засгийн үйл ажиллагаа идэвхэжсэнээр НӨАТ, нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого нэмэгдэж, улсын төсөвт мөн эергээр нөлөөлөв.

Зураг I.15. 2023 онд төсвийн орлогын бүрдүүлэлт сайн байгаа нь ...


Төсвийн орлого, ДНБ-ий хувиар



Эх сурвалж: СЯ.

Зураг I.16. ...эдийн засгийн сэргэлт, гадаад худалдаа идэвхэжсэнтэй нийцтэй байна

Төсвийн орлогын жилийн өсөлт, үүнд орлогын бүрэлдэхүүний эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

¹¹ ИӨС-ийн тухай хуульд заасан хуримтлалын дүрмийн дагуу 2022 оноос өмнө ашигт малтмалын нөөц ашигласны нийт төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг ИӨС-д шилжүүлдэг байсан. Гэвч ИӨС-д өмнө нь ийнхүү хуримтлагддаг байсан хөрөнгийг 2022, 2023 онуудад төсвийн зарлагын тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зарцуулаад байна.

Төсвийн зардал тэлж байгаа ч орлого бүрдүүлэлт сайн байгаа тул Монгол Улсын төсвийн тэнцэл сайжирлаа.

Өнгөрсөн оны эхний есөн сарын байдлаар ДНБ-ий 0.1 хувьтай тэнцэж байсан төсвийн тэнцлийн нийт ашиг 2023 оны мөн үед ДНБ-ий 4.6 хувь болж нэмэгдээд байгаа нь 2007 оноос хойших мөн үеүдэд ажиглагдсан төсвийн хамгийн өндөр ашигт тооцогдож байна. Үүний адилаар, өнгөрсөн оны эхний есөн сард ДНБ-ий 1.8 хувьтай тэнцэх алдагдалтай байсан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл буюу төсвийн хуримтлалын сангийн дүнг хассан төсвийн тэнцэл энэ оны мөн үед ДНБ-ий 3.4 хувийн ашигтай болж сайжирчээ (Зураг I.17). Гэхдээ 2023 оны эцэс гэхэд нийт төсвийн тэнцлийн ашиг ДНБ-ий 0.5 хувьд хүрч буурах төлөвтэй байна. Учир нь нэг талаас, дөрөвдүгээр улиралд төсвийн орлогын өсөлт харьцангуй удаашрах төлөвтэй байгаа бол нөгөө талаас, он гарахаас өмнө төлөвлөгөөт ажлуудаа дуусгахаар яаравчилснаар сүүлийн саруудад хөрөнгийн зардлын санхүүжилт ихэвчлэн өндөр гардаг.


Улсын өр ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр буурч байгаа ч гадаад өрийн төлөв байдал нь гадаад санхүүгийн эх үүсвэрээс ихээхэн хамааралтай, том дүнтэй өр төлбөрийг санхүүжүүлэх хэрэгцээ шаардлага хэвээр байгаа зэргээс шалтгаалан төсвийн эрсдэл, гадаад сөрөг нөлөөлөлд эмзэг өртөмтгий байдал өндөр байна. Төсвийн анхдагч тэнцэл ашигтай гарч энэ оны эхэнд хоёр Евробондын төлбөрөөс цэвэр дүнгээр 94 сая ам.долларыг, аравдугаар сард МУХБ-ны Евробондын 448 сая ам.долларыг төлөхөд түлхэц боллоо. Мөн

нэрлэсэн дүнгээр эдийн засгийн идэвхжил өндөр байгаа тул улсын өр-ДНБ-ий харьцаа 2023 оны эцэст 52.3 хувьд хүрч буурах төсөөлөлтэй байна. Улсын өр 2020 онд дээд түвшин болох ДНБ-ий 80 орчим хувьд хүрч нэмэгдэж байсан бол сүүлийн жилүүдэд ихээхэн буурсан. Гэвч Монгол Улсын өрийн бүтцэд гадаад зээл дийлэнх хувийг эзэлсээр байна. Тодруулбал, энэ оны хоёрдугаар улирлын эцэст нийт улсын өрийн 96.8 хувийг гадаад эх үүсвэртэй зээл, үүн дотроо 1/3-ийг нь зах зээлийн нөхцөлтэй арилжааны бондууд эзэлж байна.¹² Түүнчлэн, валютын ханш, эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, олон улсын зах зээл дээрх хүүгийн түвшин, гадаад санхүүжилтийн хэрэгцээ шаардлага, болзошгүй өр төлбөр зэрэг төрөл бүрийн сөрөг нөлөөлөлд улсын өрийн эмзэг, өртөмтгий байдал өндөр хэвээр байна. Одоогоор ДНБ-ий 10 гаруй хувьтай тэнцэж буй томоохон болзошгүй өр төлбөрүүдэд Эрдэнэс Таван Толгой төрийн өмчит уурхайн нүүрсний экспортын офтейк гэрээ хэлэлцээр, Төв банкнаас Засгийн газар эсхүл төрийн өмчит байгууллагад шилжүүлэхээр хүлээгдэж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр (ДНБ-ий 6 хувьтай тэнцэх), улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд олгодог татаас (энэ онд ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэх) зэрэг багтаж байна. Цаашид ойрын хугацаанд шаардагдаж буй гадаад санхүүжилтийн хэрэгцээг авч үзвэл энэ оны 12 дугаар сард Засгийн газрын баталгаатай МУХБ-ны 200 сая ам.долларын Самурай бонд, ирэх оны гуравдугаар сард Засгийн газрын 400 сая ам.долларын бондын төлбөрүүд тус тус хүлээгдэж байна.

¹² 2023 оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар улсын нийт гадаад өрийн 32.6 хувийг зах зээлийн нөхцөлтэй арилжааны бондууд эзэлж байна. Эдгээр бондуудын хувьд дунджаар бусад төрлийн олон улсын санхүүжилтээс харьцангуй богино хугацаатай, өндөр хүүтэй байдаг байна.

Зураг I.17. Төсвийн тэнцэл ихээхэн сайжирч байна

Төсвийн тэнцлийн үзүүлэлтүүд, ДНБ-ий хувиар



Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

1.5 Экспорт эрчимжиж урсгал данс ашигтай гарах, гадаад валютын улсын нөөцийг хуримтлуулахад эергээр нөлөөлж байна

Энэ оны эхний гурван улиралд нүүрсний экспорт өмнө ажиглагдаагүй түүхэн дээд түвшинд хүрч, улмаар урсгал данс сүүлийн 15 жилд анх удаа ашигтай гарав (Зураг I.18). 2023 оны эхний есөн сарын байдлаар бараа, бүтээгдэхүүний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө (Зураг I.19). Хэдийгээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан ч экспортын биет хэмжээ нэн ялангуяа, нүүрсний экспорт тухайн хугацаанд түүхэн дээд хэмжээнд хүрч нэмэгдлээ (Шигтгээ I.1, I.2-ыг үзнэ үү).¹³ Уул уурхайн экспортын биет хэмжээ ийнхүү огцом өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд: (i) 2022 оны дунд үеэс хойш Ковшид-19 цар тахлын улмаас үүссэн гадаад худалдааны саатал, доголдол шийдвэрлэгдэж, улмаар хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд зөөлөрсөн;


(ii) БНХАУ-ын хилийн ойролцоо төмөр замын тээвэрлэлтийн шинэ холболтуудыг хийж гүйцэтгэсэн, коксжих нүүрсийг түүхий эд болгон ашигладаг БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл эрчимжсэн; (iii) Оюу Толгойн далд уурхайн үйл ажиллагааг энэ оны гуравдугаар сараас хэсэгчлэн эхлүүлснээр зэсийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн болно. Харин өнгөрсөн онтой харьцуулахад уул уурхайн бус экспортын нийт экспортын өсөлтөд эзлэх хувь өссөн ч нам түвшинд хэвээр, улмаар Монгол Улсын экспортын төрөлжилт хязгаарлагдмал хэвээр байна.¹⁴ Уул уурхайн холбогдолтой тээврийн үйлчилгээний эрэлт өндөр байсан тул эхний есөн сарын байдлаар үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар тэлжээ.

¹³ 2023 оны эхний есөн сард экспортлосон нүүрсний биет хэмжээ 48.9 сая тоннд хүрч, 2019 болон 2022 оны мөн үеэс 70.4 хувь, 157 хувиар тус тус өссөн байна. Гэвч өмнөх онтой харьцуулахад 2023 онд олон улсын зах зээл дээр металлургийн (коксжих) нүүрсний үнэ 72 хувиар өссөн байхад Монголын нүүрсний экспортын үнэ 34.3 хувиар буурсан байгааг энд тэмдэглэх хэрэгтэй (Шигтгээ I.1-ийг үзнэ үү). Олон улсын зах зээл дээр үнэ болон Монголын нүүрсний экспортын үнэ хоорондын зөрүүний талаар Шигтгээ I.2-т өгүүллээ.

¹⁴ Сүүлийн үед Монгол Улсын экспортын төрөлжилт улам муудаж байна. Тодруулбал, нүүрсний экспорт өмнөх түүхэн дээд хэмжээнд хүрсэн жил буюу 2019 оны эхний гурван улиралд нийт экспортын сагсанд нүүрсний экспорт 40 хувийг эзэлж байсан бол 2023 оны эхний есөн сарын байдлаар 57 хувийг эзэлжээ.

Зураг I.18. Экспорт өсөж урсгал дансны тэнцэл ашигтай гарахад голлон нөлөөлөв

Урсгал данс, түүний бүрэлдэхүүн, ДНБ-ий хувиар



Эх сурвалж: Монголбанк.


Экспорт эрчимтэй нэмэгдсэн бол бараа, үйлчилгээний импорт ялимгүй өслөө.

ОХУ-аас Украиныг эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаанаас хойш олон улсын зах зээл дээр огцом өсөөд байсан хүнсний таваар, эрчим хүчний үнээнэ онд алгуур тогтворжиж, улмаар үнийн нөлөөг дагаад оны эхний есөн сард Монгол улсын импортын нийт зардал өмнөх оны мөн үеэс ердөө 2.8 хувиар нэмэгджээ (Зураг I.20). Хөрөнгө оруулалтын

зориулалттай машин, тоног төхөөрөмж, нүүрсний экспорттой холбоотой тээврийн үйлчилгээний эрэлт нэмэгдсэн нь импортын зардлын өсөлтийг голлон тайлбарлаж байна. Харин хэрэглээний бараа бүтээгдэхүүн, тэр дундаа хүнсний барааны импортын зардал өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурчээ. Энэ нь өмнө дурдсанчлан олон улсын зах зээл дээр хүнсний таваарын үнэ буурсантай холбоотой.

Зураг I.19. Нүүрсний экспорт нэмэгдэж нийт экспортын орлогын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлжээ


Барааны экспортын орлогын өсөлт, үүнд гол нэр төрлийн барааны эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.20. Хөрөнгө оруулалтын төслүүдтэй холбоотой түлш, капитал бараа, бүтээгдэхүүний импорт нэмэгджээ

Барааны импортын зардлын өсөлт, үүнд гол нэр төрлийн барааны эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк.


ГШХО-ын орох урсгал хязгаарлагдмал байсан тул тэр хэрээр хөрөнгийн цэвэр урсгал харьцангуй бага байв. Өнгөрсөн оны эхний есөн сарын байдлаар ДНБ-ий 9.6 хувьтай тэнцэж байсан ГШХО-ын дотогшлох урсгал энэ оны мөн үед 9 хувиар саарч, улмаар ДНБ-ий 8.4 хувьд хүрсэн нь цар тахлын өмнөх түвшнээс мэдэгдэхүйц доогуур байна (Зураг I.21). ОТ далд уурхайн бүтээн байгуулалтад шаардагдах санхүүжилтийн хэрэгцээ багасаж, уул уурхайн салбарт орж ирэх ГШХО буурах нэг шалтгаан болсон бол олон улсын санхүүгийн зах зээлийн төлөв байдал чангарч, хөрөнгө оруулагчдын сонирхол хязгаарлагдсанаар уул уурхайн бус салбарт орж ирэх ГШХО ердөө ДНБ-ий 2 хувьтай тэнцэж байна. Энэ онд эргэн төлөгдөх хуваарьтай Засгийн газрын дийлэнх Евробондын төлбөрүүдийг дахин санхүүжүүлэх замаар хөрөнгийн гадагшлах урсгалыг хязгаарласан. Гэсэн хэдий ч худалдааны зээлийн төлбөрүүд, багцын хөрөнгө оруулалтаар гадагшлах бусад

хөрөнгийн урсгал харьцангуй өндөр дүнтэй байсан тул нийт хөрөнгийн цэвэр орох урсгал сул байв.¹⁵

Хөрөнгийн дотогшлох урсгал ийнхүү сул байсан ч экспортын орлогын өсөлт давамгайлснаар гадаад валютын улсын нөөц сүүлийн 20 сарын дээд түвшинд хүрч өслөө. Өнгөрсөн жил хурдацтай буурсан гадаад валютын улсын нөөц энэ оны есдүгээр сарын эцэст 4.1 тэрбум ам. доллар буюу цар тахлын өмнөх 2019 оны эцсийн 4.3 тэрбум ам.доллартой харьцуулагдахуйц түвшинд хүрээд байгаа ч энэ нь зөвхөн 3.7 сарын валютын төлбөртэй импортын хэрэгцээг хангахуйц дүн болж байна (Зураг I.22). Үүнээс гадна, БНХАУ-ын Ардын банктай байгуулсан 1.7 тэрбум ам.долларын свот хэлцлийг 2026 оныг хүртэл дахин 3 жилээр сунгаад байгаа нь ойрын хугацаанд төлбөрийн тэнцэлд үзүүлэх дарамтыг бууруулж, зах зээлийн итгэх итгэлийг нэмэгдүүлснээр валютын ханш сулрах нөхцөлийг хязгаарласан байхаар байна.¹⁶

Зураг I.21. Зэс баяжуулах уурхайд шаардагдах хөрөнгө оруулалт буурч, олон улсын санхүүгийн зах зээл дээрх тодорхой бус байдал үргэлжилснээр ГШХО-ын дотогшлох урсгал удааширсан ...


Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал, ДНБ-ий хувиар



Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.22. ... гэсэн ч экспорт эрчимжиж, зарим гадаад өр төлбөрүүдийг дахин санхүүжүүлснээр гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд дэм боллоо

Төлбөрийн тэнцэл (ДНБ-ий хувиар) болон гадаад валютын улсын нөөц (сая ам.доллароор)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: БТ = баруун босоо тэнхлэг


¹⁵ 2023 оны тавдугаар сард эргэн төлөх хуваарьтай Гэрэгэ бондын зарим хэсэг болон 2024 оны гуравдугаар сард эргэн төлөх хуваарьтай Хуралдай бондыг дахин санхүүжүүлэхээр энэ оны эхний улиралд Засгийн газар 650 сая ам.долларын шинэ бонд гаргасан.

¹⁶ Энэ оны эхнээс төгрөгийн ханш ам.доллар болон евротой харьцуулахад тогтвортой, юаньтай харьцуулахад ялимгүй чангарлаа.

Шигтгээ I.2. Монголын нүүрсний экспортын үнэ: БНХАУ руу экспортлогч бусад улс орнуудтай харьцуулах нь

Монголын нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд хэмжээнд хүрээд байгаа хэдий ч бусад экспортлогчдоос харьцангуй бага үнээр нүүрсээ нийлүүлж ирсэн тул дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн өсөлтөөс бүрэн үр ашгаа хүртэж чадахгүй байна. Монгол Улсаас экспортын бараг ганц голлох зах зээл болох БНХАУ-д нийлүүлсэн нүүрсний экспортын биет хэмжээ өнгөрсөн оноос 2 дахин нэмэгдээд зогсохгүй БНХАУ-ын нийт коксжих нүүрсний импортын зах зээлд эзлэх хувь хэмжээ 36-аас 52 хувьд хүрч нэмэгдээд байна (Зураг Ш.3).¹⁷ Монгол Улсын хувьд ийнхүү таатай нөхцөл байдал үүссэний зэрэгцээ олон улсын зах зээл дээр нүүрсний үнэ цар тахлын өмнөхөөс давсан өндөр түвшинд хадгалагдаж байгаа ч (Шигтгээ I.1-ийг үзнэ үү) БНХАУ-д нийлүүлж буй нүүрсний экспортын үнэ олон улсын өрсөлдөгчидтэй харьцуулахад доогуур байна. ¹⁸ Уг үнийн зөрүү үүсэхэд экспортын зах зээл БНХАУ-ын хойд хэсэгт ихээр төвлөрсөн, гэрээ хэлэлцээр тохирох үеэр ил тод байдал болон үнэ тогтоох зах зээлийн чадавх сул, түүхий нүүрсийг дараагийн шатанд боловсруулах хүчин чадал харьцангуй хязгаарлагдмал зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Улмаар 2023 оны эхний есөн сарын байдлаар БНХАУ руу Монголын талаас экспортолсон коксжих нүүрсний дундаж үнэ ОХУ-ын нийлүүлэгчдээс 18 хувь орчим, худалдааны бусад түнш улс орнуудаас 50 гаруй хувиар тус тус бага байв (Зураг Ш.4).


Зураг Ш.3. Энэ онд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын зах зээлд Монголын эзлэх хувь нэмэгдсэн...



Эх сурвалж: БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар (ГЕГ). Тэмдэглэл: Тухайн жил бүрийн эхний есөн сард импортолсон нүүрсийг дүрслэв.

Зураг Ш.4. ...гэвч бусад нүүрс экспортлогчдоос харьцангуй хямд нийлүүлжээ

БНХАУ-ын импортолсон коксжих нүүрсний дундаж үнэ, худалдааны түнш орнуудаар



Эх сурвалж: БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар (ГЕГ).

Монголын нүүрсний экспортын үнийг нэмэгдүүлэх чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ оны эхнээс зах зээл дээр үнэ тогтоох үйл явцын ил тод байдлыг сайжруулж, олон улсын худалдан авагчдын дунд өрсөлдөөн бий болгон хэвшүүлэх үүднээс нүүрсийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалж байна. 2023 оны 8-9 дүгээр сард нийт экспортолсон нүүрсний дунджаар 31 орчим хувийг биржийн платформоор дамжуулан худалдаалсан нь арилжаа анх эхэлж байсан саруудад борлуулж байсан 5 хүрэхгүй хувьтай харьцуулахад нэлээд өссөн үзүүлэлт болж байна. Төрийн өмчит уул уурхайн компаниуд нүүрсээ уг биржээр дамжуулан арилжаалах үүрэгтэй бол хувийн хэвшлийн уул уурхайн компаниудын оролцоо одоогоор хязгаарлагдмал байна. Эцэст нь дурдахад, нүүрсний чанарыг сайжруулах зорилгоор төрийн өмчит томоохон нүүрсний компаниудын нэг төлөөлөл нүүрс угаах үйлдвэрээ ирэх онд ашиглалтад оруулахаар бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлжээ.

¹⁷ 2020 оны сүүлчээс эхлэн БНХАУ-аас Австралийн нүүрс нийлүүлэлтэд албан бусаар хориг тавьсантай холбогдуулан БНХАУ-ын импортод эзлэх хувь огцом буурсан. Түүнчлэн, 2022 оноос Украиныг эзлэн түрэмгийлэх үйл ажиллагааны хариу үйлдэл болгон барууны орнуудаас ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнээс шалтгаалан ОХУ нүүрсээ Азийн зах зээлд голчлон нийлүүлэх болсноор БНХАУ-ын импортод эзлэх хувь нэмэгджээ.

¹⁸ БНХАУ-ын хилийн боомтуудад тээвэрлэгдэн ирж Гаалийн байгууллагад бүртгэгдсэн, тээврийн зардал, бусад өртгийг шингээсэн үнийг харьцуулав.

2. Эдийн засгийн хэтийн төлөв, эрсдэл, бодлогын зөвлөмж

2.1. Эдийн засгийн хэтийн төлөв, эрсдэл

Энэ онд эрчимтэй идэвхжиж буй Монгол Улсын эдийн засаг ирэх онд улам хурдацтай тэлж, 6.2 хувиар өсөх төлөвтэй байна. Эдийн засаг 2023 оны эхний хагас жилийн өсөлтийн эрчээ хадгалснаар энэ онд 5.8 хувиар идэвхжих хүлээлттэй байна (Хүснэгт I.1). Оны сүүлийн хагаст нүүрсний экспорт болон хувийн хэрэглээ хүлээгдэж байснаас давах тохиолдолд эдийн засгийн өсөлт үүнээс ч өндөр байх боломжтой юм. Харин ирэх онд хувийн хэрэглээ болон төсвийн зардал тэлснээр эдийн засгийн өсөлтийг голлон бүрдүүлнэ гэж үзэж байна. Нийлүүлэлт талаас авч үзвэл, 2023 онд уналттай байсан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл сэргэхээр байна. Хувийн хэрэглээ сэргэснээр зочлох үйлчилгээ, аялал жуулчлал болон зугаа цэнгэлийн салбарын эрэлтийг нэмэгдүүлэх юм. Мөн уул уурхайн олборлолтын тээврийн салбарт үзүүлэх эерэг дам нөлөө үргэлжилснээр 2024 онд үйлчилгээний салбарын идэвхжил эрчээ хадгалах төлөвтэй байна.

Инфляц ирэх онд үргэлжлэн буурах ч энэ оноос харьцангуй алгуур буурах төлөвтэй байна. Олон улсын зах зээл дээр хүнс болон түлшний үнэ нам түвшинд байж, импортын үнэ буурах нөхцөлийг бүрдүүлэхээр байна (Шигтгээ I.1-ийг үзнэ үү). Харин хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэснээр дотоодод үйлдвэрлэгдсэн хүнсний үнийн огцом өсөлт үүсэхээс сэргийлнэ гэсэн хүлээлттэй байна. Төсвийн зардал үргэлжлэн тэлж, дотоод эрэлт сэргэснээр эрэлтийн гаралтай инфляцын дарамт нэмэгдэх ч мөнгөний хатуу бодлого баримталснаар үүний нөлөөллийг хэсэгчлэн саармагжуулна. Улмаар 2024 онд ерөнхий инфляц дунджаар 9.1 хувьд хүрэх төлөвтэй байна.

Ирэх онд төсвийн зардлын тэлэлт орлогын өсөлтөөс давахаар байна. 2023

онд 22 хувиар нэмэгдэх хүлээлттэй байгаа төсвийн нийт зардал ирэх онд 25.3 хувиар нэмж өссөнөөр 2017 оноос хойших дээд түвшин буюу ДНБ-ий 37.8 хувьд хүрэхээр байна. Төсвийн зардал ийнхүү нэмэгдэхэд ШСБ-ын хүрээнд хот-хөдөөгийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлын өсөлт голлох нөлөөг үзүүлэхээр байна.^{19, 20} Уул уурхайн салбар, нэн ялангуяа, нүүрсний салбараас төвлөрүүлэх төсвийн орлогын огцом өсөлт ирэх онд арилснаар төсвийн тэнцэл эргэн алдагдалд шилжих төлөвтэй байна.

Экспортын орлого тогтворжиж, импорт нэмэгдэхийн хэрээр 2024 онд төлбөрийн тэнцлийн дарамт дахин бий болохоор байна. Урсгал данс энэ онд бага хэмжээний алдагдалтай гарах бол ирэх оноос нүүрсний экспортын идэвхжил тогтворжиж, уул уурхайн түүхий эдийн үнэ буурч, дотоод эрэлт эрчимтэй сэргэхтэй зэрэгцээд импортын эрэлт нэмэгдэх тул урсгал дансны алдагдал ДНБ-ий 13.7 хувьд хүрч, тэлэх таамаглалтай байна. Олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал чанга хэвээр хадгалагдах тул хөрөнгийн дотогшлох урсгал төлбөрийн тэнцлийн дарамтыг бага хэмжээгээр бууруулна гэж үзэж байна. Цаашид 2023 оны эцэс болон 2024 оны эхээр хүлээгдэж буй Засгийн газрын гадаад бонд, Засгийн газрын баталгаатай гадаад бондуудын эргэн төлөлтөд нийтдээ 0.6 тэрбум ам.доллар шаардлагатай байна.

Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил үргэлжлэн эрчимжих төлөвтэй байна. 2025-2026 онуудад эдийн засгийн өсөлт дунджаар 6.3 хувьд хүрэхээр байна. Тодруулбал, ОТ-н үйлдвэрлэл 2025 он гэхэд энэ оны түвшнээс 2 дахин нэмэгдэх төлөвлөгөөтэй байгаа тул уул уурхайн

¹⁹ Үүнд төрийн албан хаагчийн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх, 2023 оны дунд үеэр баталсан тэтгэврийг инфляцтай нийцүүлэн индексжүүлэх аргачлалын дагуу нийгмийн даатгалын тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн зарцуулалтыг тэлэх арга хэмжээнүүд орсон.

²⁰ ШСБ-ын хүрээнд тусгасан томоохон гол төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр хэрэгжүүлэх төлөвтэй байна. Гэвч энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл хараахан байхгүй байна.

салбарын үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлөх төлөвтэй. УИХ-ын сонгуулийн дараа төсвийн зардал бага зэрэг тогтворжиж, уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлого өндөр байснаар

төсвийн алдагдал багасаж, улсын өрийн ДНБ-д эзлэх хувь буурах хүлээлттэй байна. Түүнчлэн, ОТ-н экспорт их хэмжээгээр тэлж, дунд хугацаанд төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгахаар байна.

Хүснэгт 1.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2021	2022	2023 төс	2024 төс	2025 төс	2026 төс
ДНБ-ий бодит өсөлт, зах зээлийн зэрэгцүүлэх үнээр	1.6	5.0	5.8	6.2	6.4	6.1
Хувийн хэрэглээ	-5.9	8.1	5.7	11.3	4.5	6.3
Төрийн хэрэглээ	9.2	6.9	13.6	11.3	1.8	3.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	17.7	13.2	7.0	15.4	1.7	7.5
Экспорт, бараа, үйлчилгээний	-14.6	32.3	42.3	3.6	20.3	6.3
Импорт, бараа, үйлчилгээний	13.6	29.1	16.8	18.4	15.4	9.2
ДНБ-ий бодит өсөлт, үйлдвэрлэлийн хүчин зүйлийн зэрэгцүүлэх үнээр	0.4	4.2	5.8	6.2	6.4	6.1
Хөдөө аж ахуй	-5.5	12.0	-10.7	11.5	5.0	6.5
Аж үйлдвэр (уул уурхайн салбарыг оруулснаар)	-2.2	-4.5	13.6	5.0	11.3	9.4
Үйлчилгээ	3.9	6.9	6.9	5.4	4.0	4.0
Инфляц (ХҮИ, жилийн дундаж)	7.1	15.2	10.2	9.1	9.0	8.7
Урсгал дансны тэнцэл (ДНБ-ий хувиар)	-13.4	-13.4	-2.1	-13.7	-9.3	-10.5
ГШХО цэвэр урсгал (ДНБ-ий хувиар)	13.1	14.1	7.9	8.2	8.5	8.6
Төсвийн тэнцэл (ДНБ-ий хувиар)	-3.0	0.7	0.5	-2.4	-0.6	-1.1
Өр (ДНБ-ий хувиар)	64.5	62.2	52.3	52.0	50.5	49.6
Төсвийн анхдагч тэнцэл (ДНБ-ий хувиар)	-1.1	2.1	2.3	-1.0	0.7	0.1

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Тэмдэглэл: Болзошгүй өр буюу БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан свот хэлцэл (2022 онд ДНБ-ий 10 хувьтай тэнцэх)-ийг улсын өрөнд оруулж тооцоогүй болно.

Эдийн засгийн хэтийн төлөвт нөлөөлж болзошгүй эрсдэлүүд их бөгөөд сөрөг талдаа давамгайлж байна. БНХАУ-тай эдийн засгийн хувьд нягт уялдаа холбоотой байгааг харгалзан үзвэл тус улсад эдийн засгийн өсөлт хүлээлтээс удаашрах тохиолдолд Монголын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь өндөр байхаар байна.²¹ БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон гангийн үйлдвэрлэлийн идэвхжил саарч, улмаар гангийн эрэлт буурах, тус улс гадаад худалдаанд баримтлах бодлогоо гэнэт өөрчлөх, өмнө байгуулсан

нүүрсний офтейк гэрээ, хэлэлцээрүүдтэй холбоотойгоор экспортын орлого орж ирэх хугацаа өөрчлөгдөх зэрэг хүчин зүйлс Монголын нүүрсний экспортын цаашдын төлөвт сорилт учруулах юм.²² Сонгуулийн өмнөх өнөөгийн нөхцөлд төсвийн зардал хүлээгдэж байснаас их хэмжээгээр тэлэх өндөр магадлалтай байдаг бөгөөд энэ нь инфляцын дарамтыг улам өдөөхөөс гадна импортын эрэлтийг нэмэгдүүлдэг учраас төсвийн болон урсгал дансны “хос” алдагдал үүсгэх өндөр эрсдэлтэй.²³ Сүүлийн үед Ойрх Дорнод дахь геополитикийн

²¹ Дэлхийн Банкны ЗАНД бүсийн эдийн засгийн тойм (2023 оны 10 дугаар сар) болон АХБ-ны Азийн хөгжлийн хэтийн төлөвийн тайлан (2023 оны 9 дугаар сар).

²² Гадаад худалдааны харилцаа сэргэж байгаатай холбогдуулан 2023 оны гуравдугаар сараас хойш Австралиас БНХАУ-д нийлүүлэх эрчим хүчний нүүрсний импорт нэмэгдэж байна.

²³ Тухайлбал, чинээлэг өрхүүдийн хэрэглээ өндөр тул НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ нь ядуу өрхүүдээс илүүтэйгээр чинээлэг өрхүүдэд илүү үр ашигтай байх юм.

нөхцөл байдал хурцадсаны улмаас газрын тосны үнэ ихээхэн өсөж, импортын төлбөр болон дотоодын түлшний үнэд нөлөөлж болзошгүй эрсдэл бий.

Эдийн засгийн цаашдын төлөвт эергээр нөлөөлж болзошгүй хүчин зүйлс голчлон богино хугацааны шинж чанартай, уул уурхайн салбарт төвлөрч байна. Экспортын тээвэрлэлтийн зориулалтаар дотоодын төмөр замын сүлжээг БНХАУ-ын талтай холбох зэрэг мега

2.2 Бодлогын зөвлөмж

Монголын эдийн засгийн тогтвортой байдал буюу байнгын гаднын сөрөг нөлөөллөөс үл хамааран тогтвортой өсөлтийг хангах чадавх нь төсвийн болон гадаад валютын нөөцийн хуримтлалыг хэр хангалттай бүрдүүлж байгаа, мөчлөг сөрсөн макро эдийн засгийн бодлогын хослолыг хэр үр дүнтэйгээр авч хэрэгжүүлж, улмаар макро эдийн засгийн хэлбэлзлийг бууруулж байгаагаас шууд хамаарна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засагт учирч байсан сөрөг хүчин зүйлсийн нөлөөлөл ирээдүйд дахин тулгарсан тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх төсвийн орон зай хязгаарлагдмал хэвээр байна (Зураг 1.23). Иймд богино хугацаанд Төв банкнаас авч хэрэгжүүлж буй макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг саармагжуулахын тулд төсвийн зардлын өсөлтийг тодорхой хэмжээнд хязгаарлах шаардлага байна. Энэ нь цаашлаад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад хөрөнгө оруулагчдын Монгол Улсын эдийн засагт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улмаар гадаад өрийг дахин санхүүжүүлэхэд илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм. Инфляцын дарамт үүсгэхгүйгээр өрхийн бодит хэрэглээг сайтар хамгаалахын тулд нийгмийн хамгааллын тогтолцоог зорилтот бүлгийг зохистой онилсон байдлаар хэрэгжүүлэх хэрэгцээ байна. Харин дунд хугацаанд ИӨС-гийн хуримтлалын дүрмийг сэргээн мөрдөж, төсвийн хуримтлалыг дахин бүрдүүлснээр Засгийн газраас ирээдүйд болзошгүй сөрөг


төслүүдийг эрчимтэй хэрэгжүүлэн дуусгах, ОТ далд уурхайн үйлдвэрлэлийг төлөвлөсөн хугацаанаас урьтаж, их хэмжээгээр нэмэгдүүлэх, түүхий эдийн үнэ төсөөлснөөс илүүтэйгээр нэмэгдэж, уул уурхайн экспортын орлогыг тэлэх, тохиролцооны шатанд хүрээд буй Орано ураны төслийг урагшлуулснаар дунд хугацаанд ГШХО-ын урсгалыг эрчимжүүлэх зэрэг хэд, хэдэн эерэг хүчин зүйлсийг дурдаж болохоор байна.

нөлөөлөлд хариу арга хэмжээ авах, ШСБ-ын хүрээнд авч хэрэгжүүлэх ирээдүйн хөрөнгө оруулалтад шаардлагатай төсвийн орон зайг бүрдүүлэх боломж үүснэ.

Монгол Улсын уул уурхайн салбар, нэн ялангуяа нүүрснээс хэт хамааралтай байдал уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн хүрээнд тулгарч буй сорилтуудыг улам хурцатгаж байна. Хэдийгээр өнөөгийн нөхцөлд уул уурхайн экспорт тэлж, макро эдийн засгийн идэвхжилд томоохон дэмжлэг үзүүлж байгаа ч цаашид Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, түүхий эдийн үнийн мөчлөгт тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд энэхүү эерэг хандлага зөвхөн богино хугацаанд ажиглагдаад өнгөрнө. Үүнээс гадна, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг нөлөөллийг бууруулах үндэсний болон олон улсын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага мөн үүснэ. Тухайлбал, шигтгээ 1.3-д дурдсанчлан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор БНХАУ нүүрсний хэрэглээгээ бууруулах тохиолдолд Монголын орлого буурах юм. Иймд Монгол Улс урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох шинэ өсөлтийн загвар эрэлхийлэх хэрэгтэй. Энэхүү тайлангийн дараагийн бүлэгт Монгол Улс уул уурхайн бус экспортын багцыг төрөлжүүлэхэд цахим салбарын хөгжил ямар боломжуудыг бий болгох, үүнд тулгарч буй бэрхшээлийн талаар өгүүлэх болно.

Зураг 1.23. Монгол улс макро эдийн засгийн өндөр эрсдэлтэй тулгарч байгаа ч түүнд хариу өгөх төсвийн орон зай хомс байна.

Эдийн засгийн ижил төстэй бүтэцтэй харьцуулахуйц улс орнуудыг хар ногоон, хөгжлийн хувьд тэмүүлэхүйц улс орнуудыг цайвар ногоон өнгөөр тэмдэглэв.



Эх сурвалж: Дэлхийн Банкны 2023 оны Төсөв, санхүүгийн тойм судалгаа.

Тэмдэглэл: Нийт эрсдэлийн индекс нь өрийн эрсдэл, орлогын эрсдэл, дэлхийн эдийн засгийн нөлөөлөлд автах эрсдэл гэсэн 3 эрсдэлийн ижил жинтэй дэд индексийг нэгтгэсэн үзүүлэлт юм. Төсвийн орон зайн индекс нь дараах 3 үзүүлэлтийн онооны энгийн дундаж болно. Үүнд: зээлжих зэрэглэлийн үнэлгээний оноо, нэгдсэн Засгийн газрын өр, Өрийн тогтвортой байдлын сүүлийн үнэлгээний оноо болно.

Шигтгээ 1.3. Нүүрс ба уур амьсгалын өөрчлөлт

Монгол Улсын нүүрснээс хэт хамааралтай байдал нь эдийн засаг, байгаль орчны хувьд сөрөг үр дагаврыг бий болгож байна. Монгол Улсын эдийн засагт нүүрс олборлолт чухал үүрэг гүйцэтгэдэг. Тодруулбал, сүүлийн 10 жилийн дунджаар нүүрс нийт барааны экспортын орлогын 30 хувь, уул уурхайн бусад бүтээгдэхүүний хамтаар нийт төсвийн орлогын 21 орчим хувийг бүрдүүлжээ. Гэвч уг хамаарлын үр дүнд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ болон биет хэмжээ их хэмжээгээр огцом хэлбэлзэхэд макро эдийн засгийн өндөр хэлбэлзэл бий болох нөхцөл бүрджээ. Хэдийгээр Монгол Улсын хүлэмжийн хийн нийт ялгаруулалт олон улстай харьцуулахад бага түвшинд хэмжигдэх ч нэг хүнд ногдох ялгаруулалтаар олон улсад 17 дугаар байранд эрэмбэлэгдэж, үүний 30 орчим хувийг нүүрснээс гаргах эрчим хүчний ялгаруулалт эзэлж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд агаарын чанараар дэлхийн хамгийн өндөр агаарын бохирдолтой хотуудын нэгт тооцогдож байна (Зураг Ш.5).

Дэлхий даяар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг улс орнууд чулуужсан түлшний хэрэглээнээс татгалзах хөдөлгөөнийг өрнүүлж байгаа нь нүүрсний цаашдын эрэлтийг сааруулах хандлагатай. Улмаар Монгол Улсын хөгжилд нүүрс олборлолт хэр урт хугацаанд чухал үүрэг гүйцэтгэх нь эргэлзээ төрүүлж байна. Монгол Улсын нүүрсний экспортын бараг дийлэнх хэсгийг худалдан авагч түнш БНХАУ-ын хувьд 2030 он гэхэд анхан шатны эрчим хүчний нийт хэрэглээнд чулуужсан түлшний эзлэх хувь хэмжээг 75 хувь хүртэл бууруулахаар Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтдоо тусган, амлалт өгөөд байна (Зураг Ш.6).²⁴ Үүнд 2050 оныг хүртэл жил бүр 0.7 хувиар хэрэглээ нь буурахаар хүлээгдэж буй нүүрсийг хамруулсан болно. Ийнхүү БНХАУ-ын зүгээс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг авснаар Монгол Улсад ихээхэн хэмжээний экспортын орлого алдагдах эрсдэл үүсэж болзошгүй юм.

²⁴ Анхдагч эрчим хүчний эх үүсвэрын хувьд цахилгаан станцад ашиглаж буй түлш гэх зэрэг аливаа хувиргалт хийхээс өмнө нөөц хэлбэрээр оршин байдгаараа бусад хоёрдогч, эцсийн, болон ашигтай эрчим хүчний эх үүсвэрүүдээс ялгаатай. Шатаахаас өмнө түүхий эдээрээ оршдог нүүрс, уран, газрын тос зэрэг түүхий эдүүд үүнд багтана.

Нүүрснээс татгалзах энэхүү шилжилтийн үйл явцыг илүү өргөн цар хүрээ бүхий хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдуулан нийцүүлэх шийдвэрийн өмнө Монгол Улс тулаад байна. Тухайлбал, нэг талаас уул уурхай, тээвэр, эрчим хүч зэрэг салбаруудад ашиглагдах нүүрс, ажлын байрны хэрэгцээ шаардлага өөрчлөгдөх бол нөгөө талаас энэхүү шилжилтэд дасан зохицохын тулд сэргээгдэх эрчим хүч, уул уурхайн дэвшилтэт санаачилгуудыг нэвтрүүлэх, эрчим хүчний үнэд байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бүрэн тусгах зэрэг асуудлыг мөн харгалзан үзэх хэрэгтэй. Нүүрснээс зөвхөн амьжиргаа, санхүүгийн хэрэгцээний хувьд хараат байхаас гадна эрчим хүч, дулаан гаргах хямд эх үүсвэр болгон ашигладаг хөдөө, орон нутгийн болон орлого багатай өрхүүдэд эдгээр арга хэмжээний үр дагавар илүү тод ажиглагдах болно. Гэхдээ нүүрсний хэрэглээнээс татгалзсанаар агаарын бохирдлыг бууруулж, улмаар ард иргэдийн эрүүл мэндэд эергээр нөлөөлөх юм. Дээрх шилжилтийн хүрээнд Монголын ард иргэдийн аж амьдрал, амьжиргаанд гарах өөрчлөлтийг чухалчлан үзэх нь зүйтэй. Ингэхдээ Бүс нутгийн болон олон улсын түвшинд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрхурдацтай өрнөж байгааг мөн харгалзан үзэх шаардлагатай.

Дэлхийн Банкнаас боловсруулж 2024 онд нийтлэхээр төлөвлөж буй Монголын уур амьсгал, хөгжлийн тайланд салбар тус бүрд болон макро, микро түвшинд хэрэгжүүлж болохуйц бодлогын хувилбаруудыг онцолж, улмаар хөгжлийн бодлогын зорилт, чиглэлийг уур амьсгалын тэсвэртэй байдалтай хэрхэн нийцүүлэх тухай өгүүлнэ. Энэхүү тайлангаар голчлон газар болон усны нөөцийн асуудлыг авч үзэх бөгөөд нүүрсний экспорт, нүүрстөрөгчийн өндөр агууламжтай эрчим хүч үйлдвэрлэлээс татгалзах шилжилтийн ач холбогдлыг онцолно.

Зураг Ш.5. Монгол нь нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалтаар өндөр орнуудын нэг юм.

Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт болон ДНБ




Эх сурвалж: Дэлхийн нүүрстөрөгчийн төсөл (2022 он).

Тэмдэглэл: Зурагт чулуужсан нүүрс, аж үйлдвэрийн салбарын ялгаруулсан хүлэмжийн хийг харуулав. Газар ашиглалтын өөрчлөлтийг оруулаагүй болно. Нэг хүнд ногдох ДНБ-ийг улс орнуудын инфляц, амьжиргааны өртгийн ялгаагаар тохируулга хийсэн.

Зураг Ш.6. Монголын нүүрсийг голлон импортлогч Хятад улс нүүрсний хэрэглээг үлэмж бууруулах төлөвтэй.

Дэлхийн нүүрсний хэрэглээ, бүсээр, сая богино тонн



Эх сурвалж: Олон улсын эрчим хүчний хэтийн төлөв 2023 он, АНУ-ын эрчим хүчний мэдээллийн алба (ЭХМА).

Тэмдэглэл: 1 богино тонн нь 2000 фунттай тэнцэнэ.

2

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ДАХЬ ХУДАЛДААНЫ БОЛОМЖУУД



Бүлэг 2: Цахим үйлчилгээний салбар дахь худалдааны боломжууд

Тээвэрлэлтийн өртөг өндөр, дэд бүтцийн хөгжил төдийлөн хангалттай бус Монгол Улстай төстэй далайд гарцгүй улс орнуудад цахим эрин үе олон улсын худалдаа, нэмүү өртгийн сүлжээнээс үр ашиг хүртэх онцгой боломжийг олгож байна. Газарзүй болон биет нөөц хөрөнгөөс үл хамааран зөвхөн авьяас ур чадвар, инновацын чадавх болон институцын тогтолцоондоо тулгуурлан олон улсын цахим талбарт өрсөлдөх боломж бий болоод байна. Цахим үйлчилгээний экспортын хувьд дэлхий даяар бусад төрлийн бараа, үйлчилгээний экспортоос илүү хурдацтай тэлж байгаа төдийгүй улс орнуудын орлогын түвшнийг нэмэгдүүлэх бололцоог олгож байна.²⁵ Монгол Улс өөрийн цахим экосистемийг шат дараатайгаар хөгжүүлснээр эдийн засгийн өсөлтөө эрчимжүүлж, аж үйлдвэрийн салбаруудаа төрөлжүүлэхээс гадна ард иргэдээ ирээдүйд эрэлттэй байх ажлын байр, боломж бололцоонд бэлтгэх ач холбогдолтой.

Энэхүү бүлэгт Монгол Улс цахим үйлчилгээний экспортоо хөгжүүлэхэд тулгарч буй үндсэн сорилтууд, боломжийн талаар урьдчилсан байдлаар хийсэн ажиглалтаас өгүүлэх бөгөөд урт хугацаанд уг салбарыг идэвхжүүлэх ерөнхий зөвлөмжийг мөн санал болгоно. Энэхүү бүлэгт удахгүй нийтлэгдэх “Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын шинжилгээ” тайлангийн үр дүнгээс хураангуйлан өгүүлж байна. Уг тайлангийн хүрээнд Монгол Улсын цахим үйлчилгээний дэд бүтэц, ур чадвар болон эрхзүйн зохицуулалтын орчны талаар нарийвчилсан мэдээлэл олж авахын тулд өмнө хийгдсэн судалгаа, бүтцийн хувьд ижил төстэй болон тэмүүлэхүйц улс орнуудтай харьцуулсан жишиг үнэлгээ, түүвэр судалгаа, холбогдох талуудтай хийсэн ярилцлагад үндэслэн дүн шинжилгээ хийлээ.²⁶ Үүнээс гадна, цахим үйлчилгээний экспортоор амжилт гаргасан улс орнуудад авч хэрэгжүүлсэн сайн туршлага, стратеги, бодлогын арга хэмжээнээс мөн дурдана.

1. Цахим шилжилтийн үйл явц болон цахим үйлчилгээний экспортод тулгарч буй сорилтууд

Монгол Улс цахим үйлчилгээний салбараа өргөжүүлэн хөгжүүлэхэд тодорхой алхам хийгээд байна. Тус улсын цахим үйлчилгээ үзүүлэх давуу талыг программ хангамж хөгжүүлэлт, харилцаа холбоо, цахим сурталчилгааны чиглэлд голлон тодорхойлогдож байна. Зураг II.1-д дурдагдсан хамгийн өндөр ашиг

орлоготой компаниудын үйл ажиллагаанаас гадна бидний хийсэн ярилцлага, түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд программ хангамж хөгжүүлэлт, цахим худалдаа, цахим сурталчилгаа, харилцаа холбооны чиглэлээр амжилт олсон түүхүүд байгаа нь эдгээр салбарт өндөр орлоготой хөрөнгө оруулалтын боломж байгааг харуулж байна.

²⁵ Цахим үйлчилгээг алсын зайнаас компьютерийн сүлжээгээр дамжуулан гүйцэтгэж буй олон улсын гүйлгээ хэмээн тодорхойлсон бол МХХТ-ийн үйлчилгээг цахимаар хүргэх үйлчилгээний мэдээллийн технологи болон харилцаа холбооны дэд бүтэцтэй холбоотой дэд хэсэг гэж тодорхойлжээ (ЭЗХАХБ 2020 он). Цахимаар хүрсэн үйлчилгээний экспорт 2005-2022 онуудад жилд дунджаар 8.1 хувиар өсөж, одоогийн байдлаар олон улсад нийт үйлчилгээний экспортын 54 хувийг эзэлж байна (ДХБ 2023 он).

²⁶ Нийт 29 оролцогч (7 бодлого боловсруулагч, 8 боловсролын салбарын төлөөлөл, хувийн компаниудыг төлөөлж 16 энтрепренер, төрийн эзэмшлийн байгууллагын 1 албан тушаалтан)-ыг түүвэр судалгаанд хамруулсан. Харин ярилцлагад 21 байгууллага (төрийн 10 байгууллага, МХХТ-ийн салбарын 3 холбоо, хувийн 6 компани, зөвлөх 1 компани, олон улсын хөгжлийн 1 байгууллага) оролцсон.

Олон улсад цахим үйлчилгээг амжилттай экспортод гаргаж буй компаниудаас нэр дурдвал Fibo Global (Казакстан дахь үүлэн технологийн үйлчилгээ үзүүлэгч), Astvision (Австрали дахь программ хангамж хөгжүүлэлтийн санаачилгууд), Infinite Solutions (АНУ, Сингапур, Филиппин улсад мэдээлэл технологийн үйлчилгээ эрхлэгч компани) зэрэг болно. Монгол Улсад МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд дунджаар гадаад эх үүсвэрээс томоохон хэмжээний санхүүжилт хараахан босгож чадаагүй бөгөөд 2022 онд нийт 70 компанийн 6 компани л нийт 7.2 сая ам.доллар татаад байна. Үүнээс Чимэгэ Системс болон World Plus Digital ХХК-ий хувьд 6.2 сая ам.долларын санхүүжилт татсан нь онцлохуйц жишээ болж байна.

Ижил төстэй улс орнуудтай харьцуулахад Монгол Улс МХХТ-ийн үйлчилгээний экспортоор мэдэгдэхүйц доогуур түвшинд байна. Тодруулбал, 2021 онд Монгол Улс 31.3 сая ам.доллар буюу ДНБ-ий 0.2 хувь, нийт үйлчилгээний экспортын 12 хувьтай тэнцэх хэмжээний МХХТ-ийн үйлчилгээг экспортолсон нь харьцуулахуйц улс орнуудаас мэдэгдэхүйц бага байна

(Зураг II.2). Томоохон зах зээлд газарзүйн болон соёлын хувьд ойр байдал, өндөр авьяас ур чадвар бүхий хүний нөөц, интернэтийн сайн холболт, хүчирхэг диаспора сүлжээ зэрэг хэд, хэдэн хүчин зүйлс нь бусад харьцуулахуйц улс орнууд Монгол Улсаас илүү хурдацтайгаар экспортоо тэлэх нөхцөлийг бүрдүүлжээ. Жишээлбэл, соёлын болон газарзүйн хувьд томоохон зах зээлд ойр байдалдаа тулгуурлан Молдав Улс МХХТ-ийн үйлчилгээний экспортоороо томоохон амжилт олж, сүүлийн таван жилийн хугацаанд ЕХ-ны улс орнуудад голлон гаргах экспортоо тав дахин нэмэгдүүлсэн байна. Математик болон байгалийн шинжлэх ухааны салбарт авьяас ур чадварын нөөц ихтэй, МХХТ-ийн салбарт төрөөс дэмжлэг үзүүлдэг, орон нутгийн их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд холбогдох мэдлэг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрүүд явуулдаг, МХХТ-ийн салбарт гаднын эзэмшлийн компаниуд ихээр орж ирсэн, төрөөс өндөр технологи бүхий салбарыг дэмжсэн санаачилгыг авч хэрэгжүүлдэг зэрэг хүчин зүйлс нь Армени улсын МХХТ-ийн үйлчилгээний экспортын өндөр гүйцэтгэлийг тайларлаж байна.

Зураг II.1. 2022 оны байдлаар Монгол Улсад олон төрөлт үйлчилгээ үзүүлдэг болон программ хангамжийн хөгжүүлэлт эрхэлдэг компаниуд орлогоороо дээгүүр жагсаж байна.


МХХТ-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд, үзүүлж буй үйлчилгээний төрөл болон нийт МХХТ-ийн компаниудад эзлэх хувиар



Эх сурвалж: Crunchbase өгөгдөлд суурилсан мэргэжилтний тооцоо.

Зураг II.2. Ижил төстэй бүтэц бүхий улс орнуудтай харьцуулахад Монгол Улс МХХТ-ийн үйлчилгээний экспортоор хоцрогдолтой байна.

Төлбөрийн тэнцэлд бүртгэгдсэн МХХТ-ийн үйлчилгээний экспорт, ДНБ-ий хувиар



Эх сурвалж: Төлбөрийн тэнцлийн статистик мэдээлэлд суурилсан мэргэжилтний тооцоо.

Цахим шилжилтэд ийнхүү зарим талаар ахиц дэвшил гарч байгаа ч цахим үйлчилгээний салбарын хөгжилд сөргөөр нөлөөлөхүйц томоохон саад бэрхшээлүүд байсаар байна. Монгол Улс цахим шилжилтийн индексээр С-ангилалд багтсан хэвээр байгаа нь МХХТ-ийн дэд бүтэц, ур чадвар, инновац болон бизнесийн орчны хувьд томоохон сорилттой тулгарч буйг харуулж байна.²⁷ Хэдийгээр харилцаа холбоо болон интернэт нэвтрэлтэд ахиц дэвшил гарч байгаа ч Монгол Улсын цахим дэд бүтцийн хөгжилд онцлохуйц хэд, хэдэн саад бэрхшээл тулгарсаар байна. Тухайлбал, сүлжээний хурд удаан, сүлжээний холболт хоцрогдол ихтэй, кибер аюулгүй байдал сул байна. Цахим салбарт өндөр ур чадвартай ажиллах хүчин дутагдалтай байна. Үүнээс гадна, хууль эрхзүйн зохицуулалтын орчин дутмаг байгаа нь цахим салбарын өсөлтийг хязгаарлаж байна. Үүнд оюуны өмч, өгөгдлийн нууцлал хадгалах, зах зээлийг хүртээмжтэй байлгах, шударга өрсөлдөөний

бодлого, олон улсын өгөгдлийн гарцад нэвтрэх, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах болон хууль эрхзүйн тогтолцооны хүрээнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.

Гар утсыг өргөн хүрээнд эзэмшиж, гар утасны өргөн зурвасын идэвхтэй хэрэглээ өндөр түвшинд байгаа ч МХХТ-ийн хүртээмж хязгаарлагдмал байна. Тодруулбал, 2023 оны гуравдугаар сарын байдлаар Монгол Улс нийт 180 улсаас гар утасны дундаж хурдаар 109, өргөн зурвасын хурдаар 75 дугаар байрт тустус эрэмбэлэгдэж байна. Ийм хэмжээний хурдаар бизнесүүд интернэтэд хандах, улмаар цахим үйлчилгээ хөгжүүлэхэд хүндрэлтэй.²⁸ Түүнчлэн, 2022 оны Мобайл холбооны глобал системийн холбооноос зарладаг Гар утасны холболтын индексээр Монгол Улс нийт 170 орноос 83 дугаар байрт эрэмбэлэгдсэн нь гар утасны төхөөрөмжийн өртөг, онлайн аюулгүй байдал болон спектрийн хувьд асуудал байгааг илэрхийлж байна.²⁹

Зураг II.3. Монгол Улсын кибер аюулгүй байдал сул байна

2020 онд ОУХХХ-ноос зарладаг Кибер аюулгүй байдлын олон улсын индексээр Монгол Улсын үнэлэгдсэн оноо (дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэр оноо = 26.2/50)



Эх сурвалж: ОУХХХ-ны Кибер аюулгүй байдлын олон улсын индекс 2020 он.
Тэмдэглэл: Өндөр оноо нь гүйцэтгэл сайн байсныг илэрхийлнэ.

²⁷ Ким Жеон Ён, Пак Жонсү болон Жун Сынхва нарын боловсруулсан “Ази, Номхон далайн бүс дэх цахим шилжилт: Цахим хуваагдал улам хурцдан, өсөлтийн зөрүү нэмэгдэж байна (2022 он)”. Цахим шилжилтийн үнэлгээгээр нийт 100 онооноос 20-39 оноо авсан улс орнуудыг С-ангилалд багтаана.

²⁸ Монгол Улсад гар утсаар интернэтээс татах медиан хурд 18.39 Мбит/с, илгээх медиан хурд 7.61 Мбит/с, сүлжээний холболтын медиан хоцрогдол 23 миллисекунд байна. Харин суурин өргөн зурвасын сүлжээгээр интернэтээс татах медиан хурд 54.49 Мбит/с, илгээх медиан хурд 34.37 Мбит/с байгаа бол сүлжээний холболтын медиан хоцрогдол харьцангуй бага буюу ердөө 4 миллисекундээр хэмжигджээ. (Хурдны тест, 2023 он).

²⁹ Мобайл холбооны глобал системийн холбоо (2022 он).

Үүнээс гадна, сүлжээ холболтын хоцрогдол их, кибер аюулгүй байдлын чадавх сул байна. Монгол Улсын олон улсын хуурай газрын сүлжээтэй холбогдсон сүлжээний хоцрогдол 109-146 миллисекундын хооронд хэлбэлзэж байгаа нь онлайн тоглоом, видео хурал уулзалтад оролцох, санхүүгийн зах зээл дээрх арилжааг цаг алдалгүй гүйцэтгэх, үүлэнд суурилсан үйлчилгээг үзүүлэх болон юмсын интернэтийн тоног төхөөрөмжийг үр дүнтэй ажиллуулах зэрэг бодит цагийн горимоор ажиллах цахим хэрэглээний гүйцэтгэлийг хязгаарлаж байна.³⁰ Харин 2020 онд Олон улсын харилцаа холбооны холбоо (ОУХХХ)-ноос зарладаг Кибер аюулгүй байдлын олон улсын индексээр Монгол Улс нийт 182 орноос 120 дугаар байрт эрэмбэлэгджээ (Зураг II.3).

Монгол Улс цахим үйлчилгээний салбарт шаардлагатай ур чадвар, авьяасыг хөгжүүлэх чиглэлээр ихээхэн саадтай тулгарч байна. Монгол Улсын хувьд англи хэлний түвшин харьцангуй доогуур үнэлэгдэж байгаа бөгөөд “Боловсролыг

тэргүүлэх ээлжид” холбооноос зарладаг Англи хэлний түвшний индексээр нийт 111 орноос 72 дугаар байрт эрэмбэлэгджээ.³¹ Харин 2022 оны Олон улсын ур чадварын өрсөлдөөний индексээр Монгол Улс нийт 172 орноос 71 дүгээр байрт эрэмбэлэгджээ.³² Технологийн салбарынхан дунд хийсэн түүвэр судалгаагаар ур чадварын дутагдлыг тэдэнд тулгарч буй хамгийн томоохон саад бэрхшээлийн нэгээр тодруулсан (Зураг II.4). Мөн түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд болон боловсролын байгууллага хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь энэхүү ур чадварын дутагдлыг улам хурцатгаж байна. Ажил олгогчдоос цахим, МХХТ-ийн чиглэлээр шаардагдах тусгайлсан ур чадварын эрэлт хэрэгцээг тодорхойлох албан механизм, платформ байхгүй байна. Иймд их сургуулиуд болон сургалтын байгууллагууд цахим үйлчилгээний зах зээлийн тусгайлсан хэрэгцээ шаардлагад тулгуурлахаас илүүтэйгээр ерөнхий хандлагад суурилан сургалтын хөтөлбөрүүдээ боловсруулж байна.

Зураг II.4. Ажил олгогчдын хувьд хангалттай ур чадвар бүхий техникийн мэргэжилтэн олоход хүндрэлтэй байна.

Ажил олгогчдын дунд явуулсан түүвэр судалгааны хүрээнд техникийн мэргэжилтэн олоход гарч буй хүндрэлүүд



Эх сурвалж: ЦХХХЯ, 2021 он.

³⁰ Дү болон Мажүүр нар (2023 он).

³¹ Боловсролыг тэргүүлэх ээлжид холбоо (2022 он).

³² Ланвин болон Монтейро нар (2022 он).

Гарааны бизнесийн экосистемийн хувьд зарим талаар найдлага төрүүлж байгаа ч дөнгөж хөгжлийн эхэн үе шатанд байна. 2022 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гарааны бизнесийн экосистемийн хүрээнд явуулсан түүвэр судалгааны үр дүнгээр нийт 452 тэрбум төгрөг буюу 131 сая ам.доллар, ДНБ-ий 0.8 хувьтай тэнцэх хэмжээний үнэлгээ бүхий 80 гарааны бизнесүүд 1381 ажлын байрыг бий болгожээ.³³ Эдгээрээс дийлэнх гарааны бизнесүүд боловсролын технологи, хиймэл оюун ухаан, их өгөгдөл болон аналитик дүн шинжилгээний чиглэлээр сүүлийн гурван жилийн хугацаанд байгуулагдсан байна. Уг экосистем дөнгөж хөгжлийн эхэн үе шатанд байгаа ба нэг тэрбум ам.доллороос дээш үнэлгээ бүхий гарааны бизнес одоогоор байхгүй, харин цөөн тооны компаниуд хувьцаанд суурилсан А төрлийн санхүүжилт буюу гаднын эх үүсвэрээс татаж болохуйц хамгийн анхан шатны томоохон санхүүжилтийг босгоод байна. Засгийн газар дотор Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) болон Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-наас гарааны бизнесүүдэд дэмжлэг үзүүлэх талаар давхардсан чиг үүрэгтэй, харилцан уялдаагүй байгаа тул бодлогын үр дүн хязгаарлагдаж байна.

Хууль, эрхзүйн зохицуулалтын орчин сүүлийн үед сайжирч байгаа ч цахим салбарын хөгжлийг дэмжихэд хангалтгүй байх магадлалтай юм. Тодруулбал, оюуны өмчийн зохицуулалтыг сайжруулах, өгөгдлийн нууцлалыг хамгаалах эрхзүйн зохицуулалтыг боловсруулах, зах зээлийн хүртээмж болон зах зээлд нэвтрэхэд учирч буй саад бэрхшээлийг үнэлэх, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих, олон улсын өгөгдлийн гарцад холбогдох холболтыг өргөжүүлэх, тодорхой удирдамж, мэдээллээр хангах, өгөгдлийн аюулгүй байдал болон хууль эрхзүйн тогтолцоог дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байна. Эдгээр зохицуулалт сул байснаар тус салбарт олон улсын хөрөнгө оруулагчид орж ирэх боломжийг хязгаарлаж байж болзошгүй юм. Дэлхийн эдийн засгийн форумаас 2020 онд технологи, цахим салбарын 310 ААН-үүдийн төлөөлөл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргагч нарын дунд явуулсан олон улсын түүвэр судалгаагаар шинэ төрлийн цахим үйл ажиллагаанд хөрөнгө оруулахад тэдний голлон анхаарлаа хандуулдаг тэргүүлэх гурван хүчин зүйлийг тодорхойлжээ. Үүнд өгөгдлийн аюулгүй байдлын зохицуулалт, оюуны өмчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, өгөгдлийн нууцлалыг хамгаалах зохицуулалт зэрэг багтсан байна.

2. Цахим үйлчилгээний экспортыг хөхиүлэн дэмжих нь

Монгол Улсад тулгарч буй эдгээр саад, бэрхшээлийг арилгахад чиглэсэн дотоод бодлогын арга хэмжээ чухал юм. Энэ хэсэгт дээр тодорхойлсон зарим сорилтыг хэрхэн даван туулах талаар ерөнхий зөвлөмжийг танилцуулъя.

Цахим дэд бүтэц хөгжүүлэх

Монгол Улс цахим дэд бүтэцтэй холбоотойгоор (i) харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах, (ii) үндэсний блокчейн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлд

арга хэмжээ авч хэрэгжүүлбэл үрашигтай. Богино хугацаанд Монгол Улс интернэтийн хурдыг дээшлүүлэх, олон улсын хуурай замын сүлжээний холболтын хоцрогдлыг бууруулах зорилгоор мэдрэгч тус бүрийг шилэн кабелиар холбох гэх мэтчилэн харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах шаардлагатай байна. Тодруулбал, Олон улсын өргөн зурвасын холбооноос өрхийн хэрэглэгчдэд 50 Гбит/с, албан байгууллагын хэрэглэгчдэд 3.2 Тбит/с хүртэл хэмжээний хурдаар дамжуулах чадвартай сүлжээ ашиглахыг зөвлөмж болгодог байна.

³³ Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА) (2022 он).

³⁴ Харин дунд, урт хугацаанд үндэсний блокчейн дэд бүтцийг хөгжүүлснээр өртөг багатай, үр ашигтай, салбарын хэрэгцээг сайтар хангахуйц, аюулгүй найдвартай төдийгүй ил тод гүйлгээний платформ бий болгоно. ³⁵ Дуу хөгжим, тоглоом болон эрүүл мэндийн салбарууд аль хэдийн блокчейн технологийн аюулгүй байдал, ил тод байдлыг үр ашигтайгаар ашиглаад эхэлжээ. Зарим улс орнуудад төрөөс блокчейн санаачилгыг авч хэрэгжүүлж эхэлсэн бол Энэтхэг улсын хувьд бүр үндэсний стратегиа боловсруулаад байна.

Ур чадвар, авьяасыг хөгжүүлэх

Монгол Улс цахим салбарт шаардагдаж буй ур чадварын эрэлт хэрэгцээг тодорхойлж, ажиглах зорилгоор цахим ур чадварын ажиглалтын төв байгуулах, үүнтэй зэрэгцээд өндөр эрэлттэй байгаа ур чадвар эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах боломжтой. Энэхүү цахим ажиглалтын төвд хөдөлмөрийн зах зээл дээр үүсэж буй эрэлт хэрэгцээ, шинээр бий болж буй технологийн дэвшил зэрэгт ажиглалт хийх аналитик шинжилгээний чадавхыг хөгжүүлэх хэрэгтэй. Олон улсад ЕХ-ны Ур чадварын панорама төв, ЭЗХАХБ-ын Ажлын ур чадвар мэдээллийн сан, Зүүн өмнөд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем, Персийн булангийн Хөдөлмөрийн зах зээлийн ажиглалтын төв, Цахим аж амьдралын олон улсын ажиглалтын төв, Колумбын Ур чадварын зөвлөлийн ажиглалтын төв болон Дэлхийн эдийн засгийн форумын ажлын байр сэргээх ажиглалтын төв зэрэг жишиг болохуйц сайн загваруудыг дурдаж болохоор байна.

Харин авьяас, ур чадварын дутмаг байдлыг нөхөх үүднээс өндөр эрэлт хэрэгцээтэй ур чадварыг эзэмшүүлэх, оюутнуудыг ажлын нөхцөлд тулгуурласан сурах боломжоор хангах зорилго бүхий боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, Франц Улсад авч хэрэгжүүлж буй Эколе 42 хөтөлбөртэй адил зарчмаар буюу элсэлтэд албан боловсролын үнэмлэх, диплом шаардахгүй, улмаар сургалтын хөтөлбөрийн хүртээмжийг илүү өргөжүүлж, техникийн болон хувь хүний харилцааны ур чадварыг хослуулан эзэмшүүлэхэд чиглэсэн байдлаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой. ³⁶

Уул уурхайн инженерчлэлийн мэргэжлийн үйлчилгээг экспортлох чадавхаа амжилттай хөгжүүлж чадсан Чилийн туршлагыг жишиг болгон Монгол Улс уул уурхайн салбарт тусгайлан чиглэгдсэн цахим үйлчилгээний салбарыг хөгжүүлж болно. 1990-ээд оноос эхлэн Чили уул уурхайн инженерчлэлийн үйлчилгээний үндсэн төв болж чадсан. Тодруулбал, зэсийн салбарт үлгэр жишээ болохуйц төвүүдийг Чили олон улсад зэсийн төсөл боловсруулах тэргүүлэх үүрэг бүхий нэгж болгон хөгжүүлж чадсан. Үүний адилаар АНУ-д үүсэн байгуулагдсан, Монгол эзэмшил бүхий Тригтек зэрэг компаниуд уул уурхайн салбарт олон улсын зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс гадна Австрали, АНУ зэрэг улсаас геологийн дэвшилтэт программ хангамжийг Азийн үйлчлүүлэгчдэд нийлүүлдэг. Энэхүү бизнесийн загварыг дотоодын нөхцөлд хуулбарлан нэвтрүүлэх боломжтой. Жишээлбэл, ОТ далд уурхайн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд

³⁴ Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах тусгайлан бодлогыг энд авч үзээгүй бөгөөд энэ талаар тусдаа дүн шинжилгээ хийх шаардлагатай.

³⁵ Монгол Улсад МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Жамуха групп үндэсний блокчейн дэд бүтцийн өөрийн хувилбарыг хөгжүүлээд байна. Уг хувилбарт суурилан үндэсний блокчейн дэд бүтцийг бий болгох боломжтой. Монгол Улсын Үндэсний Мэдээллийн Төв, Гамшгийн Сэргээн Босголтын Төвүүдийг уг дэд бүтцийн хэсэг болгон нэмж болно. Үүнээс гадна Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй харилцаа холбооны компаниуд уг дэд бүтцийн хамтарсан түнш болж болно.

³⁶ Эколе 42 нь компьютерийн шинжлэх ухааны боловсрол олгоход чиглэсэн хувийн санхүүжилттэй сургууль болно. 2013 онд Парис хотноо байгуулагдсанаас хойш энэхүү өвөрмөц сургууль нь уламжлалт профессор багш нарын оролцоогүйгээр 24 цагийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг. Оюутан-оюутан хоорондын заах арга зүй, төсөлд суурилсан сургалтын хөтөлбөрийг чухалчлах замаар боловсролд инновацын арга барилыг хөхиүлэн дэмждэг.

олж авсан мэдлэгтээ тулгуурлан Монгол Улс улам инженерчлэлийн чиглэлээр цахим үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бололцоо байна.

Хил дамнасан хамтын ажиллагаа, харилцан уялдаа холбоог өргөжүүлэх

Монгол Улс цахим эдийн засгийн түншлэлийн гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж, үүний үр ашгаас хүртэх боломжтой. Цахим түншлэлийн гэрээ хэлэлцээрүүдийг байгуулснаар түнш орнуудтай цахим эдийн засаг хоорондын харилцан уялдаа холбоог дэмжих, улмаар цахим үйлчилгээний салбар дахь гадаад худалдааг хөхиүлэн дэмжих чухал ач холбогдолтой. Сингапурын Цахим эдийн засгийн түншлэлийн гэрээ болон ЕХ-Сингапур хоорондын цахим түншлэл зэрэг гэрээ хэлэлцээрүүд нь цаасны оролцоогүй гадаад худалдаа хийх нөхцөлийг бүрдүүлэн, хил дамнасан төлбөр тооцоог аюулгүй гүйцэтгэх боломжоор хангаж, улмаар шинээр гарч ирж буй финтек компаниудад дэмжлэг болж байна.^{37, 38} Түүнчлэн, эдгээр гэрээ хэлэлцээрүүд нь цахим үйлчилгээ хоорондын харилцан үйлчлэлийг өргөжүүлэхээс гадна хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, өгөгдөлд түшиглэсэн инновацыг дэмжих ач холбогдолтой.

Дунд хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад олон улсын дүрэм журмыг мөрдүүлж, хэвшүүлэх зорилгоор боловсролын байгууллагууд, хувийн хэвшил, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх бололцоотой.

Цахим үйлчилгээ экспортолж буй Монгол компаниудын хувьд дүрэм журам, зохицуулалтын чухал шаардлагуудыг хангахад улам хүндрэлтэй болж байна. Өгөгдлийн аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий журам, ЕХ-ны Цахим үйлчилгээний хууль зэрэг нь олон улсад мөрдөгдөж буй хууль эрхзүйн зохицуулалтын томоохон жишээ төлөөлөл болно.^{39, 40, 41} Үүнд Өгөгдлийн аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий журмаар өгөгдлийг хамгаалах болон нууцлалыг хадгалах чиглэлээр чанд хатуу дүрмийг тогтоож өгсөн бол Цахим үйлчилгээний хуулиар онлайн дундын зуучлагч нарын эрх үүргийг тодорхойлсон. Эдгээр олон улсын стандартыг мөрдүүлж хэвшүүлэх талаар олон талт хамтарсан сургалтын арга барил баримталснаар компаниуд өөрсдөө өгөгдлийн аюулгүй байдлаа хамгаалах үйл явцаа сайжруулж, тавигдаж буй шаардлагын талаар байнгын шинэ мэдээлэлтэй байх, улмаар холбогдох стандартыг мөрдөж, хэвшүүлэхэд түлхэц болох ач холбогдолтой юм.

³⁷ Сингапур, Чили, Шинэ Зеланд улс хооронд байгуулсан цахим эдийн засгийн түншлэлийн гэрээ нь цахим худалдааг дэмжих, цахимжуулалтаас урган гарч буй асуудлыг шийдвэрлэх зорилготой хамтын ажиллагааны тогтолцоо юм (Чили, Шинэ Зеланд, Сингапур улс 2020 он).

³⁸ Энэхүү түншлэлийн хүрээнд өгөгдлийн нууцлалыг хадгалах гэрээ, шинэ дэвшилтэт технологийн тусламжтайгаар хил дамнасан өгөгдлийн урсгалыг дэмжих зорилготой. Үүнд гаалийн тариф, тарифын бус хориг саад, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрх, төрийн худалдан авах үйл ажиллагаа болон тогтвортой хөгжил гэх мэт худалдаатай холбоотой асуудлаар үл ялгаварлах заалтуудыг тусгасан (ЕХ болон Сингапур улс 2023 он).

³⁹ Өгөгдлийн аюулгүй байдлыг хамгаалах ерөнхий журам нь ЕХ дахь хувь хүний мэдээллийг хамгаалах нууцлалын цогц зохицуулалт болно. ЕХ руу цахим үйлчилгээ экспортолж буй компаниуд уг ерөнхий журмыг мөрдөх ёстой байдаг бол ЕХ-ноос гадагш хувь хүний өгөгдөл мэдээлэл дамжуулахад компаниуд хууль ёсны дагуу өгөгдөл дамжуулах тусгай механизм мөрдөхийг шаардсан хязгаарлалт тогтоодог. Уг ерөнхий журмыг мөрдөөгүй тохиолдолд өндөр хэмжээний торгууль, шийтгэл ногдуулна.

⁴⁰ Цахим үйлчилгээний хууль нь бизнес-бизнес, бизнес-үйлчлүүлэгч хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бараа, үйлчилгээ, бүтээлийн хүртээмжийг хангах платформ гэх мэт цахим зуучлалын үйлчилгээ үзүүлэгч нарт хамаарна. Уг хуулийн хүрээнд хууль бус агуулгыг устгах, хэрэглэгчдийн үндсэн эрх ашгийг онлайн нөхцөлд хамгаалах, онлайн платформын ил тод байдал, хариуцлагын тогтолцоог онцолдог юм.

⁴¹ ЕХ цахим эдийн засгийн хувьд хамгийн дэвшилтэт эрх зүйн зохицуулалттай бөгөөд энэ нь олон улсад жишиг болж байна.

Хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих

Цөөн хүн амтай улмаас өгөгдлийн олдоц хязгаарлагдмал байдаг асуудлыг шийдвэрлэж, хувийн хэвшлүүдэд өгөгдөл мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор МУЗГ-аас өгөгдөлд тулгуурласан цогц бодлого боловсруулах боломжтой. Уг бодлогын хүрээнд хувь хэрэглэгчид өөрт байгаа өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулан мөнгөжүүлэх боломж олгох зах зээл, технологид түшиглэсэн бизнесүүдэд үйлчлэх юмсын интернэт болон өгөгдлийн урсгалын платформ, өгөгдөл солилцооны үр ашигтай, ил тод байдлыг хангахуйц төвлөрсөн бус өгөгдлийн зах зээл зэрэг төрөл бүрийн өгөгдлийн зах зээлийг хянаж зохицуулах тогтолцоог бий болгох боломжтой. Мөн уг бодлогын хүрээнд Европын өгөгдлийн орон зайн загвартай төстэй байдлаар гол салбаруудыг илүү чухалчилсан өгөгдөл солилцооны платформуудыг хамруулах боломжтой юм. Үүнээс гадна Засгийн газраас синтетик өгөгдөл, зах зээл хоорондын харилцан үйлчлэл, өгөгдлийн стандартыг хөхиүлэн дэмжих, улмаар өгөгдлийн чанар, аюулгүй байдлыг ханган, хүртээмжийг сайжруулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Монгол Улс цахим гарааны бизнесийн хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц тодорхой чиг үүрэг бүхий институцийн бүтцийг байгуулж болно. Тухайлбал, Startup SG нь Сингапурын Худалдаа, аж үйлдвэрийн яамны дэргэдэх хууль ёсны зөвлөл болох Enterprise Singapore-г харьяалагддаг

бөгөөд Сингапурын нийт гарааны бизнес эрхлэгчдийн хамтын эрх ашгийг төлөөлөх үүрэгтэй. Уг байгууллагатай төстэй бүтцийг Монгол Улсад бий болгон, дэмжлэг туслалцааг нэг цэгт төвлөрүүлж, цахим гарааны бизнесүүдийн нэгдмэл эрх ашгийг төлөөлүүлэх боломжтой гэж үзэж байна. Сингапурын Засгийн газраас гарааны бизнесүүд, хөрөнгө оруулагчид болон инкубаторуудад олон улсын энтрепренер нарыг татан оролцуулахад дэмжлэг үзүүлэх, менторшип зөвлөгөө болон анхдагч капитал хөрөнгө олгох, зээлийн хөтөлбөрт хамруулахаас гадна хамтарсан хөрөнгө оруулалтын боломжийг хөрөнгө оруулагчдад олгох гэх зэргээр олон төрлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн Сингапур дахь Олон улсын Финтек Хакселератортай төстэй байдлаар Монгол Улс өрсөлдөөнийг бий болгон, олон улсын сорилтыг зохион байгуулах хэлбэрээр инновацыг эрэлхийлж, улмаар гарааны бизнесийн экосистемийн хөгжлөө улам эрчимжүүлэх боломжтой.⁴² Засгийн газраас шинэ бизнесийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалтын сан, судалгаа болон хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, эзэмшигчдийн оруулсан хөрөнгөтэй тэнцүү хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх санхүүжилтийн хөтөлбөр, хувьцааны эзэмшилд нөлөөлөхгүй зээл болон буцалтгүй тусламжийн санхүүжилт зэрэг олон улсад ашиглагдаж буй загваруудыг технологийн компаниудын санхүүжилтэд нэвтрүүлж болно.

⁴² Олон улсын финтек Хакселератор нь Сингапур улсын Төв банкнаас хэрэгжүүлдэг дэлхийн дахинд үүсч буй бодит асуудлыг шийдвэрлэх боломжийг эрэлхийлсэн жил бүр хэрэгждэг хөтөлбөр юм.

Ашигласан материалын жагсаалт

- Asian Development Bank. "Asian Development Outlook: Continued Growth and Moderating Inflation, But Risks Are Rising - September 2023". Asian Development Bank, Manila.
- Australian Government: Office of the Chief Economist. "Resources and Energy Quarterly - September 2023". Department of Industry, Science and Resources, Commonwealth of Australia.
- Bank of Mongolia. "Monetary Policy Guidelines 2024 (draft submitted to the Parliament)". <https://www.mongolbank.mn/mn/r/5490>.
- Bank of Mongolia: Statistics. <https://stat.mongolbank.mn>.
- Chinese General Administration of Customs (GAC): Statistics. <http://english.customs.gov.cn>.
- Chile NZ Singapore. 2020. "Digital Economy Partnership Agreement". <https://www.mfat.govt.nz/en/trade/free-trade-agreements/free-trade-agreements-in-force/digital-economy-partnership-agreement-depa/depa-text-and-resources/#bookmark6>.
- Crunchbase Database. <https://www.crunchbase.com/>.
- Development Bank of Mongolia. "Daily Market Updates". https://www.dbm.mn/news?cat_id=2&offset=0.
- Du, C. and Majoor, R. 2023. "Market Analysis Consultancy for Green Data Center Strategy for Mongolia".
- EF Education First. 2022. "EF English Proficiency Index: Mongolia". <https://www.ef.com/wwen/epi/regions/asia/mongolia/>.
- Erdenes Tavan Tolgoi. "Coal washing plant is expected to be operational in July". <https://ett.mn/mn/news/single/5276>.
- EU and Singapore. 2023. "EU-Singapore Digital Partnership". <https://digital-strategy.ec.europa.eu/en/library/eu-singapore-digital-partnership>.
- Global Carbon Project. 2022. "Global Carbon Atlas". <https://globalcarbonatlas.org/>.
- GSMA: Mobile Connectivity Index. 2022. <http://www.mobileconnectivityindex.com/connectivityIndex.html>.
- International Energy Agency. "Coal Market Update - July 2023". <https://www.iea.org/reports/coal-market-update-july-2023>.
- International Telecommunication Union: Global Cybersecurity Index. <https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx>.
- JICA. 2022. "Baseline Survey of the Mongolian Start-up Ecosystem". https://www.jica.go.jp/Resource/mongolia/english/office/topics/gh13tc000000yef0-att/220413_01_en.pdf.
- Kim, Jeong Yoon, Jongsur Park, and Seunghwa Jun. 2022. "Digital Transformation Landscape in Asia and the Pacific: Aggravated Digital Divide and Widening Growth Gap". <http://www.unescap.org/kp>.
- Lanvin, B. and Monteiro, F. 2022. "The Global Talent Competitiveness Index 2022 - The Tectonics of Talent: Is the World Drifting Towards Increased Talent Inequalities?". INSEAD.
- "Law on Future Heritage Fund". 2016. <https://legalinfo.mn/mn/detail/11707>.
- Ministry of Finance: General Government Budget Statistics. <http://iltod.mof.gov.mn/opendata>.
- Ministry of Finance. "Government Debt Statistical Bulletin - 2nd Quarter of 2023". https://mof.gov.mn/files/uploads/article/DebtBulletin_MN_project_2023.2.pdf.
- Ministry of Finance. "2023 Budget Amendment (draft submitted to the Parliament)". <http://iltod.mof.gov.mn/legacy?type=46&subType=35&year=2023&legalId=597>.
- Ministry of Finance. "2024 Budget Document (draft submitted to the Parliament)". <http://iltod.mof.gov.mn/legacy?type=46&subType=35&year=2024&legalId=610>.
- Mongolian Customs Service: Statistics. <https://gaali.mn/statistic>.

- Mongolian Stock Exchange: Mineral Commodities Trading Statistics. <https://mse.mn/mn/content/list/349>.
- National Statistics Office: Mongolian Statistical Information Service. <https://1212.mn>.
- OECD/WTO/IMF. 2020. "Handbook on Measuring Digital Trade: Version 1". <https://www.oecd.org/sdd/its/Handbook-on-Measuring-Digital-Trade-Version-1.pdf>.
- "Parliament Resolution No. 106 on New Revival Policy". 2021. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431&type=3>.
- Rio Tinto. "Second Quarter Operations Review 2023". <https://www.riotinto.com/en/invest/financial-news-performance/production>.
- U.S. Energy Information Administration. "International Energy Outlook 2023". <https://www.eia.gov/outlooks/ieo>.
- World Bank: Commodity Markets Data. <https://www.worldbank.org/en/research/commodity-markets>.
- World Bank: World Development Indicators. <https://databank.worldbank.org>.
- World Bank. 2022. "China: Country Climate and Development Report - October 2022". World Bank, Beijing.
- . 2023. "China Economic Update: Priority Reforms Key for Sustaining Growth and Achieving China's Long-Term Goals - June 2023". World Bank, Beijing.
- . 2023. "China: Macro Poverty Outlook - October 2023". World Bank, Beijing.
- . 2023. "Commodity Markets Outlook: Under the Shadow of Geopolitical Risks - October 2023". World Bank, Washington, DC.
- . 2023. "East Asia and Pacific Economic Update: Services for Development - October 2023". World Bank, Washington, DC.
- . 2023. "Global Economic Prospects: Weakening Growth, Financial Risks - June 2023". World Bank, Washington, DC.
- . 2023. "Mongolia Economic Update: Partial Recovery and Lingering Risk - April 2023". World Bank, Ulaanbaatar.
- . 2023. "Mongolia: Macro Poverty Outlook - October 2023". World Bank, Ulaanbaatar.
- . 2023. "Mongolia Trade Work: Trade Competitiveness Diagnostic and Exploring Potential Trade Opportunities". World Bank, Ulaanbaatar. *Forthcoming*.
- World Economic Forum. 2020. "Digital FDI Policies, Regulations and Measures To Attract FDI In The Digital Economy: White paper". <https://www.weforum.org/whitepapers/digital-fdi-policies-regulations-and-measures-to-attract-fdi-in-the-digital-economy/>.
- World Trade Organization. 2023. "Global Trade Outlook and Statistics". World Trade Organization, Switzerland.



ДЭЛХИЙН БАНК

ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП



1818 H Street NW
Washington DC 20433



Tel: 202-473-1000



www.worldbank.org